



БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ЯАМ



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарын хөгжлийн агентлаг

Үндэсний түшиц



БОЛОВСРОЛЫН  
ХҮРЭЭЛЭН

Орон нутгийн хэрэгжүүлэгч



ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
БОЛОВСРОЛЫН САН (FEE)-ИЙН  
ГИШҮҮН

БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЭДЭЭЛЭЛ СУРГАЛТЫН  
ТӨВ НҮТБ

# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ II ТӨСӨЛ

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД:

- ТХБ-II төслийн үндэсний баг төсөл хэрэгжүүлэгч аймаг, нийслэлийн тогтвортой хөгжлийн төлөөх загвар сургуулиуд дээр ажиллалаа
- ТХБ-II төслийн жижиг төслийн үр шимийг 30 сургуулийн 29000 гаруй сурагч, 30000 гаруй эцэг эх, 2600 гаруй багш, ажиллагсад шууд хүртлээ
- “Нэгэн үеийн сүйрэл” хэмээн тодорхойлоод буй боловсролын салбар дахь хямралаас гарах нь улс орон бүрийн тулгамдсан асуудал болж байна
- ТХБ төсөл хэрэгжүүлэгч сургуулиуд туршлагаа түгээж, харилцан суралцаж эхэллээ
- Тогтвортой хөгжил, хүний эрхтэй хөгжлийн бодлогоо уяж, төсөв хөрөнгөө төлөвлөхийг санууллаа
- Сурагч, багш нарынхаа сэтгэл зүйг анзаарч мэдэрч, хичээл сургалтаа төлөвлөж, удирдахыг зөвлөлөө

## ГАРЧИГ

|              |     |
|--------------|-----|
| ДОТООД МЭДЭЭ | 1   |
| БИД          | 2-3 |
| ЗОЧИН        | 4   |
| ТҮНШЛЭЛ      | 5-6 |
| ДҮҮРЭГ       | 7   |
| НЭГ СЭДВЭЭР  | 8   |
| ОРОН НУТАГ   | 9   |

## ЗУРВАС “ТХБ” ЦАХИМ СОНИНХОО 5 ДАХЬ ДУГААРЫГ ТАНД ИЛГЭЭЛЭЭ

Монгол улсын Засгийн газар, Швейцарын холбооны улсын Засгийн газрын дэмжлэгээр хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн боловсрол II” төслийн үндсэн зорилго нь тогтвортой хөгжлийн боловсролоор дамжуулан Монгол Улсын иргэдэд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хариуцлагатай, тэгш хүртээмжтэй, тогтвортой ирээдүйг бий болгоход дэмжлэг үзүүлэх явдал юм.

“Тогтвортой хөгжлийн боловсрол II” төслийн түшиц байгууллага нь БШУЯ-ны харьяа Боловсролын хүрээлэн бөгөөд тус хүрээлэн дээр боловсрол, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд, тэдгээрийн харьяа агентлаг, төрийн бус байгууллагаас бүрдсэн төслийн Техникийн зөвлөн зохицуулах үндэсний баг /ТЗЗҮБ/ ажиллаж байна. Дээрх зорилго, үйл ажиллагааны зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, тогтвортой хөгжлийн боловсрол, ногоон хөгжлийн талаар тогтвортой хөгжлийн боловсрол олгогчид, мөн олон нийтэд мэдээ мэдээлэл, мэдлэг түгээхээр төслийн зүгээс “Тогтвортой хөгжлийн боловсрол” буюу “ТХБ” цахим сонингоо улирал тутам уншигч танд хүргэж байгаа билээ. Шинэ оны босгон дээр танд сонинхоо 5 дахь дугаарыг хүргэж байгаадаа төслийн хамт олон баяртай байна.

Уншигч танд сонин нийтлэлтэй холбоотой санал хүсэлт, мэдээ мэдээлэл байх аваас бид хэзээд нээлттэй.

“ТХБ” цахим сонин редакцийн зөвлөл.

## ҮЙЛ ЯВДАЛ ТХБ ТӨСӨЛ САЙН СУРГУУЛИЙН СОЁЛЫГ ТҮГЭЭНЭ ГЭДЭГТ ИТГЭЖ БАЙНА



ТХБ-II төслийн баг, БОМСТ-тэй хамтран төсөл хэрэгжүүлэгч аймаг, дүүргийн техникийн зөвлөн зохицуулах орон нутгийн баг (ТЗЗОНБ)-ийн гишүүдтэй өнгөрсөн 11 дүгээр сард УБ хотноо уулзалт-хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлал, ТХБ-II төслийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, орон нутгийн түвшинд “ТХБ-Үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хэлэлцэх, цаашидын арга хэмжээний чиглэлийг тодорхойлох, гишүүдийг идэвхжүүлэх зорилготой тус уулзалт-хэлэлцүүлэгт төслийн техникийн зөвлөн зохицуулах үндэсний болоод орон нутгийн багийн гишүүд, аймгийн удирдлагуудын төлөөлөл нийт 114 хүн хамрагдаа. Тэдний 99 нь зорилтод аймаг, дүүргийн багийн гишүүд /үүнээс эрэгтэй-24, эмэгтэй-75/, 15 нь орон нутгийн удирдлагуудын төлөөлөл байлаа.

Аймаг орон нутгийн удирдлагууд ийн ач холбогдол өгч оролцсон нь төслийн зүгээс үйл ажиллагааныхаа талаар нэгдсэн мэдээлэл хангах, цаашид хамтын ажиллагаа өрнүүлэхэд чухал ач холбогдолтой болсон гэж зохион байгуулагчид үзэж байна.

Уулзалт хэлэлцүүлгийн үеэр БШУЯ-ны Бага, дунд боловсролын газрын дарга Т.Ням-Очир хэлэхдээ “Одоо сурч байгаа generation Z үеийнхний араас generation альфа үеийнхэн сургуулийн босго алхлаа. Ийнхүү хөгжлийн цоо шинэ үеийнхэнд generation Y буюу миллениум үеийнхэн хичээл сургалтыг удирдаж, тэднийг дараагийн үед бэлдэнэ гэдэг бол ТХБ-ын үндэс суурь юм. Тэдэнд ямар тодорхойгүй байдал үлдээж өгөх гэж байгаага бид ойлгож, тодорхойгүй ирээдүй, цаг үед бэлэн байх ёстой” гэлээ.

Мөн “Сурагч, багш нарынхаа сэтгэл зүйг анзаарч мэдэрч, хичээл сургалтаа төлөвлөж, удирдах ёстой. Сургууль дээр зөвхөн багш, нийгмийн ажилтан биш, сэтгэл зүйч, эмч, хоол зүйч гээд бүхэл бүтэн дэмжлэгийн баг бий болж байна” гээд зөвхөн багшид даатгадаг, найддаг уламжлалт хандлагаа өөрчлөхийг зөвлөсөн юм.

ТХБ-II төслийн үр дүнд хүүхдүүдийнхээ хүсэл сонирхол, хэрэгцээнд тулгуурлаж ажилладаг сайн сургуулийн соёл тогтоно гэж БШУЯ найдаж байна.

## СУРГУУЛИУД АСУУДАЛ, АРГА ЗАМАА БАГ, ХАМТ ОЛНООРОО ТОДОРХОЙЛЖ БАЙГАА НЬ ТОМ АМЖИЛТ



ТХБ-II төслийн ТЗЗҮБ-ийн гишүүд өнгөрсөн 9, 10 дугаар сард төсөл хэрэгжүүлэгч Архангай, Булган, Хэнтий, Орхон, Хөвсгөл, Ховд аймаг, нийслэлийн Сонгинохайрхан, Баянгол дүүрэг дэх тогтвортой хөгжлийн төлөөх загвар сургуулиуд дээр тус төслийн техникийн зөвлөн зохицуулах орон нутгийн багтай хамтран ажиллалаа. Багууд сургуулиудын төслийн үйл явцтай танилцаж, зөвлөн туслах, сайн туршлагыг илрүүлэх, багш, сурагч, эцэг эхтэй ярилцах, аймаг, дүүргийн багийн гишүүдтэй зөвлөлдөх уулзалт-хэлэлцүүлэг хийх, тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлал, агуулга, арга зүйтэй холбоотой мэдээлэл солилцох зэрэг ажлыг зохион байгууллаа. /Дэлгэрэнгүй мэдээллийг 2 дугаар нүүрнээс уншина уу/

## 2030 ОН ГЭХЭД БШУ-НЫ САЛБАР 65 САЯ МОД ТАРИХ БОЛОМЖТОЙ



Боловсрол, шинжлэх ухааны яам Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод тарих хөдөлгөөн” ийг амжилттай хэрэгжүүлэхэд шинжлэх ухааны мэдлэг, шинэ технологи, аргагүй, чадварлаг боловсон хүчин үүнтэй уялдан бий болох хууль эрхзүйн таатай орчныг бүрдүүлэх ажилд манлайлан оролцохоо мэдэгдсэн. Тэрбум мод тарих хөдөлгөөнийг ойг нөхөн сэргээх, хот суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, газар тариалан, дэд


## ТХБ-ДОТООД МЭДЭЭ

бүтцийн хамгаалалтын зурвас байгуулах, хуурай гандуу бус нутгийг ойжуулах гэсэн үндсэн хэд хэдэн чиглэлээр их дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд хамтран сургалт судалгаатай нь цогц хэлбэрээр зохион байгуулж ажиллах юм байна.

БШУЯ-ны харьяа их дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд нь ойн мэргэжилтэн бэлтгэх, чадавхжуулах, тарьц суулгац ургуулах, үрийн хангамж, генетик нөөц бүрдүүлэх, тарьц суулгацын ургалт, амьдралын эрчмийг нэмэгдүүлэх, цаашид арчилж ургуулах чиглэлээр шинэ технологи, шинжлэх ухааны мэдлэг, арга зүй нэвтрүүлэх ажилд тэргүүлэн оролцох зорилт тавьж байгааг салбарын сайд нь мэдэгдлээ. Боловсрол, шинжлэх ухааны салбар жилдээ 8 100 000 гаруй мод тарина. 2030 он гэхэд нийт 65 сая мод тарих боломжтой гэж тооцсон байна.

## СУРГАЛТ-СУДАЛГАА

### ХҮҮХДИЙН СУРАХ ИДЭВХ БУУРСАН НЬ ХИЧЭЭЛИЙН ХОЦРОГДОЛ АРИЛГАХАД ХҮНДРЭЛ ҮҮСГЭЖ БАЙНА



«ХОСОЛСОН СУРГАЛТЫН АРГА ЗҮЙД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ»  
сургалт, судалгаа, зөвлөн туслах үйл ажиллагаанд 2000 гаруй бэлчээдийг амжилттай хамрагдаа



Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /БМДИ/ өнгөрсөн 10, 11-р сард “Хосолсон сургалтын арга зүйд дэмжлэг үзүүлэх” сургалт, судалгаа, зөвлөн туслах үйл ажиллагааг 19 аймгийн 312 сум, Багануур дүүргийн нийт 500 сургуулийн 2000 гаруй багш, ажилтанд зохион байгууллаа. Сургалтад аймгийн төвийн 158, сумын 312, багийн 30 сургуулийн төлөөлөл хамрагдаж, цахим, танхим хосолсон сургалтын арга зүйд суралцаж, сургуулийн түвшний сургагч багшаар бэлтгэгдсэн байна.

Энэ үеэр хичээл, сургалт зохион байгуулахад тулгамдаж буй бэрхшээлийг багш нар дараах байдлаар тодорхойлжээ.

- Цахим хичээл явуулах шаардлага хангасан тоног төхөөрөмжгүй
- Сургуулийн интернетийн хурд хүрэлцдэггүй /ялангуяа сумын сургуулиудад/
- Хосолсон сургалтын үед багшийн ачаалал 2 дахин ихэсч, илүү цагаар ажилладаг ч чалигийн нэмэгдэлгүй
- Цахим болон танхимын хосолсон сургалтын онол арга зүй, хөтөлбөр боловсруулах мэдлэг, туршлага, арга зүй дутагддаг
- Сурагчдад эцэг эх, гэр бүлийн дэмжлэг хангалтгүй, цахим хичээлээ судлах төхөөрөмж, интернетийн орчин хангалтгүй /гар утас, интернет төхөөрөмж, дата/

Мөн хоёр жилийн хугацаанд хүүхдүүд дэлгэцийн хэт хамааралтай болж, сурах идэвх хүсэл сонирхол багассан, сурах арга барил, нийгэмшил, сэтгэл хөдлөлийн чадварын хоцрогдол ихэвчлэн үүссэн зэрэг нь хоцрогдол нөхөх, арилгахад хүндрэл үүсгэж байна. Малчин өрх, хөдөө сумдын эцэг эхчүүд цахимаар хичээллэж буй 7 хоногийг амралт гэж үзэн хүүхдүүдээ авч явах сонирхол их байдаг гэжээ.

Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд БМДИ ерөнхий боловсролын сургууль, багш нарт шаардагдах дэмжлэг зохицуулалтыг тодорхойллоо.



Үргэлжлэл:



Архангай, Булган, Хэнтий, Орхон, Хөвсгөл, Ховд аймаг, нийслэлийн 30 сургууль нь ТХБ-II төслийн түшиц сургуулиуд бөгөөд сургууль тус бүр нийт 15 сая төгрөгийн өртөгтэй жижиг төсөл хэрэгжүүлж байгаа юм. Төсвийн тал нь ТХБ-II төслөөс, тал нь орон нутгийн төсвөөс санхүүжиж байна. Сурагч, эцэг эх, багш сургуулийн удирдлага багаар, бүхлээр ажиллах арга хандлагад суралцах, тогтвортой хөгжлийн төлөө зорилго, үйл ажиллагаагаа тодорхойлж, үйлдэл хийх сэдэл тэмүүллийг бий болгож, улмаар тухайн орчин, орон нутагтаа нөлөөлж, олон нийтийг тогтвортой хөгжлийн төлөө уриалж, сэдэлжүүлдгээрээ энэ төслийн үнэ цэнэ оршдог.

БШУЯ, БОАЖЯ, Швейцарын хөгжлийн агентлагын хамтран хэрэгжүүлж буй ТХБ-II төслийн үндэсний түшиц байгууллагаар Боловсролын хүрээлэн, орон нутгийн түшиц байгууллагаар Байгаль орчин, мэдээлэл сургалтын төв /БОСМТ/ ТББ ажиллаж байна.



**Үр дүн ололт амжилт:**

Дээрх аймаг, дүүргийн нийт 30 сургууль багаараа “Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага ба өөрийн үнэлгээний арга зүй” аргачлал, загварчлалаар үнэлгээ хийж, тулгамдсан асуудлаа илрүүлж, шийдвэрлэх хүрээнд жижиг төсөл санаачлан 2020 оны 5 сараас хэрэгжүүлж эхэлсэн юм. Ингэснээр сургуулийн амьдралын бүхий л хүрээнд тогтвортой байдлын зарчмуудыг интеграцчилж, СБААХ-ыг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа нь томоохон ололт болж байна.



Сургууль бүр тулгамдсан асуудлаа баг хамт олноороо тодорхойлж, шийдвэрлэх арга зам шийдлийг мөн сургуулийн баг, олон нийтийн оролцоотойгоор гаргаж тавьж байгаа нь том амжилт гэж талууд дүгнэлээ.



Дээрх үйл ажиллагаанд 30 сургуулийн багш удирдах ажилтан, сургуулийн төслийн багийн төлөөлөл, аймаг орон нутгийн удирдах ажилтан гээд нийт 500 гаруй хүн оролцлоо.

Сургуулиудын ТХБ-II төсөл сайн хэрэгжиж, олон үр дүнг бий болгож байна гэж дүгнэлээ. /Графикаас харх/

**Төслийн үр шимийг хүртэгчид**

| Шууд   | Сурагч            | 29422 |
|--------|-------------------|-------|
| Шууд   | Багш              | 1832  |
|        | Ажилтан           | 776   |
|        | Эцэг эх олон нийт | 29758 |
| Дам    | Сурагч            | 21720 |
|        | Багш              | 1658  |
|        | Ажилтан           | 1904  |
|        | Эцэг эх олон нийт | 36544 |
| Нөлөөт | Сурагч            | 20710 |
|        | Багш              | 1178  |
|        | Ажилтан           | 1975  |
|        | Эцэг эх олон нийт | 62634 |

Төслийн үр шим хүртэгчдийн дээрх тоо сургуулийн өөрийн үнэлгээгээр тодорхойлсон асуудлаа шийдвэрлэхэд эцэг эх, олон нийтийн оролцоо дэмжлэгийг сайн татаж, Тогтвортой хөгжлийн төлөөх загвар сургууль болохын төлөө хамтран ажиллаж байгааг илтгэж байна.



**Цаашид анхаарах асуудал:**

- Сургуулиудын төсөл харилцан адилгүй хэрэгжиж байгаа нь
- Цар тахал, үнийн өсөлт-хөөрөгдөл, хөрөнгө санхүүгийн дутагдал, зарим аймаг, дүүргийн орон нутгийн санхүүжилт хугацаандаа шийдэгдээгүй байдал
- Сургуулийн удирдлагын, багийн ур чадвар, хамт олны уур амьсгал, багийн мэдлэг чадвар зэргээс хамаарч байна гэж үзлээ.

\*\*\*

Бид төсөл гэхээр их хэмжээний мөнгөөр зөвхөн биет зүйлийг бүтээж босгодог гэж ойлгох нь бий. Тэгвэл ТХБ-II төслийн хүрээнд 30 ерөнхий боловсролын сургуулийн хэрэгжүүлж байгаа бичил төслүүд нь бага хөрөнгөөр сургууль бүхлээр ажиллах арга хандлагыг хэрэгжүүлэх соёлыг суулгаж, улмаар тогтвортой хөгжлийн боловсрол түгээж байгаагаараа онцлог юм.

Төслөөр дамжуулан сургууль бүхлээрээ, сурагч, эцэг эхчүүдтэйгээ хамтарч ажиллаж байгаа нь, олж авсан мэдлэгээ түшиглэн шинэ бүтээл, санаа гаргаж, хүмүүсийн зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэж байгаа нь энэ төслийн давуу тал болж байна. Чухам яаж, ямар арга хэлбэрээр юу хийж бүтээж байгааг зарим сургуулийн жишээгээр хүргэе.

\*\*\*

**122 ДУГААР СУРГУУЛЬ ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ИНКУБАТОР ТӨВТЭЙ БОЛЛОО**

Нийслэлийн томоохон сургуулийн нэг, ТХБ-II төслийн түшиц 122 дугаар сургуулийн хамт олон ТХБ-II төслийн хүрээнд “Хүүхэд хөгжлийн инкубатор” төв байгуулаад байна. Сурагч, эцэг эхчүүд, сургуулийн хамт олон хамтран тус төвдөө тогтвортой хөгжлийн төлөө олон төрлийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөжээ. Цаашид дүүргийнхээ 26 сургуулийн 60 000 гаруй хүүхдэд тогтвортой хөгжлийн төлөөх мэдлэг, үйл ажиллагаагаа түгээн дэлгэрүүлж, туршлагаасаа хуваалцана гэлээ.



**Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.БАДАМХАНД:**

122 дугаар сургууль нь нийт 3240 гаруй хүүхэдтэй Сонгинохайрхан дүүргийн 34-р хорооны 9800 гаруй иргэд, эцэг эхчүүдэд хамаарал бүхий сургууль. Тус сургууль ТХБ-II төслийн жижиг төслөөр байгуулсан “Хүүхэд хөгжлийн инкубатор” төвдөө эхний ээлжинд сурагчдын хоцрогдлыг арилгах сургалт явуулахаар хөтөлбөрөө гаргалаа. Интернэтгүй, нэг утсаар ээлжилж хичээлдээ ордог зэрэг бэрхшээлээс болж зарим сурагчид хичээлээр их хоцрогдсон. Мөн сэтгэлзүйн үйлчилгээ хүргэх хэрэгцээ шаардлага ч их байна. Ийм байдлаар зорилтод бүлгийн хүүхдүүд, тэдний ар гэрийнхэнд үйлчлэх, тэгш биш байдлыг бууруулах, арилгах олон чиглэлээр тус төв ажиллана. Судалгаагаар 122 удугаар сургуулийн нийт сурагчдын 20 хувь нь зорилтод бүлэгт орж байна.

**СУРАГЧИД ӨВ СОЁЛЫН ӨРГӨӨНДӨӨ ХИЧЭЭЛЛЭХ ДУРТАЙ**

Ховд аймгийн Мөнххайрхан сумын дунд сургуулийн хашаан доторх зургаан ханат өргөө гэр хөл хөдөлгөөнгүй өнжих нь ховор. Учир энэ өргөөнд монгол хэл, түүх, иргэний ёс зүй, технологи, дуу хөгжим зэрэг хичээл орж, олон нийтийг хамарсан олон ч үйл өрнөдөг. Эсгий ширдэг, торгон хөшиг, хуучны болоод монгол ахуйн эд хэрэглэлтэй цэмцгэр гоё гэрт хүүхдүүд тухлах, тоглох, хичээллэх тун дуртай. Сая орсон монгол хэлний хичээлээр багш нь эмээлийн тоноглол хяр, бүүрэг, ганзага, дөрөө, олом жирмийг үзүүлж, үгнүүдийг таниулан тайлбарласан бол өмнөх технологийн хичээлээр урианхай ясны дээл хувцсыг танилцуулж, зүүх ороох оёдлын технологийг заажээ. Заримдаа монгол оньсон наадгайн технологи ч орно. Дуу хөгжмийн хичээл “Өв соёлын өргөө”нд ёстой л ардын урлагын бэсрэг тоглолт аятай өрнөдөг байна. Энэ бол Ховд аймгийн Мөнххайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн хамт олны ТХБ-II төслийн дэмжлэгтэй байгуулсан “Өв соёлын өргөө”.

Өргөө гэрийн модыг төслийн санхүүжилтээр авсан бол гадна бүрээс доторх эд хэрэглэлийн заримыг сургуулийн багш, эцэг эхчүүд, сурагчдынхаа хамт урлаж, заримыг нь хандиваар авчээ. Мөн урианхай ясны дээл хувцас, морин хуур, саалийн матмал хувин, оньсон тоглоомууд нь нутгийнхны, эцэг эхчүүдийн хандив юм байна.



**Ховд аймгийн Засаг даргын тамгын газрын Боловсролын хэлтсийн мэргэжилтэн, ТХБ-II төслийн ОНТЗЗБ-ын гишүүн Д.БАТНАСАН:**

“Энэ бол ТХБ-II төслийн жижиг төслийг сургуульдаа хэрэгжүүлсний нэг үр дүн. Урианхай ясны хэл, соёл, зан заншлыг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн уламжлуулах зорилгоор өргөөгөө барьж байгуулсан нь үр дүнгээ өгч байна. Ийм байдлаар ТХБ-II төслийн жижиг төслийг хэрэгжүүлэгч Ховд аймгийн сургуулиуд үйл ажиллагаараа дамжуулан ТХБ-ын үзэл санааг орон нутгийнхаа иргэдэд хүргэх зорилготой ажиллаж байна” гэлээ.

Мөнххайрхан сумын сургууль өнгөрсөн намар урлагийн наадмаа цахимаар хийхдээ “Өв соёлын өргөө” өө түшиглэсэн улам сонирхолтой, өгөөжтэй болжээ.



**СУРГУУЛИЙН ТУРШЛАГЫГ СУМААРАА ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ**

Хэнтий аймгийн Баян-Адарга сумын ерөнхий боловсролын сургууль сурагч, багш, эцэг эхчүүдийнхээ дунд судалгаа хийхэд хог хаягдлыг бууруулж, цэвэр цэмцгэр орчинд амьдрах хандлагыг төлөвшүүлэхийг хүсчээ. Ингээд тус сургуулийн багш, сурагчдын төлөөлөл хог хаягдлаа бууруулах, ангилан ялгах, дахин ашиглах зэрэг зөв дадал хэвшилд суралцах, энэ чиглэлээр сумынхаа иргэдийг уриалах, тэдэнд нөлөөлөх зорилготой “Цэвэр цэмцгэр бидний орчин” төслийг санаачилсан нь “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төсөлд шалгарсан юм. Сургуулийнхаа дахивар хог хаягдал хуванцар сав цуглуулж тушааж хэвшсэн ажлаа “ТХБ-II” төслөөр үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Мөн сумынхаа бүх байгууллагад хог хаягдлын хор уршгийг таниулж, хогоо зөв ангилан ялгах талаар мэдээлэл хүргэж, экологийн ул мөрийн судалгааг хийжээ. Сургуулийнхаа орчинд хог ангилан ялгах савнууд байрлуулж, ухаалаг, ногоон худалдан авалт хийх дадал хэвшилээ сэргээсэн байна.

**Баян-Адарга сумын сургуулийн захирал Б.АНХБАЯР:** “Сурагч, багш нар сумаа цэвэр цэмцгэр болгох ажлыг сургуулиасаа эхлэхийг санал болгож, “ТХБ-II” төслийн дэмжлэгийг хүлээсэн. Хогоо бууруулахад зөв худалдан авалт, эрүүл хооллолт мөн чухал болохыг ч бүгд хүлээн зөвшөөрсөн. Эцэст нь бид хүүхдээр



дамжуулж эцэг эх, айл өрхөд хогоо бууруулж, ангилан хаядаг байх, дахин ашиглах, эрүүл зөв хооллох зэрэг дадал хэвшлийг тогтоохыг хусч үйл ажиллагаагаа явуулж байна. Ингэснээр Баян-Адрага сумынхаа хог хаягдлыг тодорхой хэмжээгээр бууруулж байна” гэлээ.

Орон нутгийн удирдлага сургуулийн энэ туршлагыг Баян-Адрага сумандаа хэрэгжүүлж, хогоо хаягдлаа бууруулах, ангилан ялгах, дахин ашиглах зэргээр менежментээ өөрчилж эхэлсэн байна. Мөн тус сургуулийн автомашингүй өдрийн санаачлагыг дэмжиж, сумаараа долоо хоног бүрийн лхагва гаригийг автомашингүй өдөр болгон хэвшиж байна.



Тээврийн хэрэгслээр малаа хариулж дадаад байгаа малчид энэ өдөр мориороо малаа хариулж, хүүхдүүдээ сургуулиас авахдаа мориор, эсвэл явган ирж дадаж байгааг Баян-Адрага сумын иргэд ярилаа. Энэ бүх ажлыг сургууль бүхлээр ажиллах арга хандлагын үндсэн дээр явуулж байна.

\*\*\*

### ХЭВТЭЖ УНШСАН Ч БОЛНО

Булган аймгийн “Эрдмийн Өргөө” сургууль шинэ эко номын сангаараа зөвхөн сандал ширээн дээр сууж ном уншдаг хэв маягийг өөрчилжээ. Бас танхимаа монгол уламжлал, наадгай, нутгийнхаа ховор амьтан, ургамал байгалийн онцлог өгүүлсэн зураг, эд зүйлсээр тохижуулсан байна. Энэ бол сургуулийн хамт олны ТХБ-II төслийн жижиг төслөөр байгуулсан хоёр танхимтай эко номын сан. “Эко орчин –Хүүхэд хөгжил” танхимд зарим хичээлээс гадна анги, хамт олон, сурагчдын клуб “Ном унших чөлөө” зарлан, номын тэмдэглэл хөтлөх, ханын сонин гаргах, зохиолчдын мэндэлсэн өдрийг тэмдэглэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж байна.



“Манай сургууль СБААХ-аар тулгамдсан асуудлаа тодорхойлоход олонх нь эко номын сантай болох санал гаргасан. Энэ бүхэн нь хүүхдүүдийг номонд дурлуулж, чөлөөт цагаа зөв үйлд зориулах, танин мэдэхэд тус дэм болж байгаагаас гадна нутгийн иргэд, албан байгууллага, сургуулиудад гэр, байгууллагадаа жишиг номын сан байгуулах эсдэл санааг өгсөн бүтээлч ажил болсон. Саяхан Бугат сумын сургуулийн баг туршилага судлаад явлаа” гэж тус сургуулийн биологийн багш Х.МӨНХЗҮЛ танилцууллаа.



“Эко орчин-хүүхэд хөгжил” танхимын үр шимийг “Эрдмийн өргөө” лаборатори сургуулийн 100 гаруй багш, ажиллагсад, 1400 гаруй суралцагч, 2 870 гаруй эцэг эх шууд хүртэж байна. Сургуулийн эко номын сан номоо худалдаж авахаас гадна багш, эцэг эх, сурагчид, орон нутгийн иргэд хандиваар нийт 400 гаруй номтой болжээ.

Ийнхүү Булган аймагт “Эрдмийн Өргөө” сургууль, Хишиг-Өндөр, Могод сум, Хялганат тосгоны ерөнхий боловсролын сургуулиуд өөрийн асуудал, хэрэгцээгээ хамт олноороо тодорхойлж, өөрчлөх, шинэчлэх, бүтээх арга замаа хэлэлцэн ТХБ-II төслийн хүрээнд шийдвэрлэж байна. Тухайлбал дээрх сургуулиуд байгалийн ухааны туршилтын талбай, эко зуслан, орон нутгийн хөгжлийн танхимыг ТХБ-ын жижиг төслөөрөө байгуулж, заримыг нь ашиглалтад орууллаа.

\*\*\*

# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ II ТӨСӨЛ

## Үндэсний түшиц байгууллага БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН

### Төслийн орон нутгийн хэрэгжүүлэгч байгууллага БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЭЭЛЭЛ СУРГАЛТЫН ТӨВ /БОМСТ/ НҮТББ

#### 2021 ОНД БИД

- ТХБ-II төслийн “Техникийн зөвлөн зохицуулах үндэсний баг” гишүүдээ /ТЗЗҮБ/ ТХБ-ын чиглэлээр цуврал сургалтуудад хамруулах, төлөөлсөн байгууллагадаа түгээн дэлгэрүүлэх, ТХБ-ын загвар сургуулиудын үйл ажиллагаанд мониторинг хийх, байгууллагадаа бичил төсөл хэрэгжүүлэх чиглэлээр тэдний чадавхийг бэхжүүлэхэд анхаарч ажиллалаа. Ингэснээр тухайн байгууллагуудын үйл ажиллагаанд ТХБ-ын үзэл санааг тусган хэрэгжүүлэх улмаар үндэсний хэмжээнд ТХБ-ыг институтчилах боломж бүрдэж байна.
- ТХБ-II төсөл “Тогтвортой хөгжлийн боловсролын төлөөх хамтын санаачилга, түншлэл” сэдэвт үндэсний виртуал нэгдсэн арга хэмжээг БОАЖЯ, БШУЯ, төслийн түшиц байгууллага-Боловсролын Хүрээлэн, төслийг орон нутагт хэрэгжүүлэгч Байгаль Орчны Мэдээлэл Сургалтын Төвийн нэгдсэн удирдлага, манлайлал дор ТЗЗҮБ-ийн гишүүн байгууллагуудын оролцоотойгоор ЮНЕСКО-той хамтран зохион байгууллаа. Хамгийн олон буюу 108.500 гаруй оролцогчтой, олон талыг нэг талбарт буюу цахим ордонд уулзуулж чадсан тус чуулган нь ТХБ-ын үзэл санааг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, нэгдсэн ойлголттой болох, салбар хоорондын хамтын ажиллагаа, уялдааг бий болгоход чухал ач холбогдолтой үйл ажиллагаа боллоо.
- ТХБ-ын үзэл санаа, агуулгыг ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт интеграцчилах зөвлөмж боловсруулах ажлаа эхэллээ. Энэ нь 2024 онд хийх сургалтын хөтөлбөрийн шинэчлэлд дэмжлэг үзүүлэх,
- ТХБ-ын үзэл санааг ерөнхий боловсролын агуулга, арга зүйд тусгах, хэрэгжүүлэх нэг нөхцөл бүрдүүлэх бөгөөд үүнийг төслийн нэг гол үр нөлөө гэж үзэж байна.
- ТХБ-II төслийг хэрэгжүүлэгч байгууллага БОМСТ нь ЕБС-ийн менежментэд “Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага” (СБААХ)-ыг нэвтрүүлэх замаар “Тогтвортой хөгжлийн төлөөх загвар сургууль”-ийг хөгжүүлж, дэмжих хүрээнд “СБААХ ба өөрийн үнэлгээний арга зүй” багц гарын авлагыг салбарын эрдэмтэн судлаачдын хамт боловсруулж, сургуулийн багийг чадавхжуулах сургалт-үйл ажиллагааг Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Нийт 2800 гаруй хүнд хүрч ажиллалаа.
- Боловсролын үнэлгээний төвийн дэргэд элсэлтийн ерөнхий шалгалт өгөх сурагчдад сэтгэл зүйн зөвлөгөө өгөх чатбоксын үйлчилгээг нээж, боловсролын сэтгэл зүйчдийг бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр ТББ-уудтай хамтран ажиллаж, хүний нөөц, ажиллах орчинг бүрдүүлэхэд анхаарч ажиллалаа. Төслийн зүгээс нэг сургуульд 4-5 сая, нийт 120 гаруй сая төгрөгийн хөрөнгө орууллаа.
- Төслийн зорилтот 6 аймаг, 2 дүүргийн 30 сургуулийн хэрэгжүүлж буй жижиг төслийн хэрэгжилтэд мониторинг-зөвлөн туслах үйл ажиллагааг цахим хэлбэрээр удаа дараа зохион байгуулахын зэрэгцээ орон нутагт хамтарсан багаар ажиллалаа.

#### 2022 ОНД БИД

- Дэлхий нийтийн анхаарлын төвд буй ТХБ-ын боловсролын 8 чиглэлийн 25 дэд сэдвээр сургалтын модулийг гурван ялгаатай түвшинд боловсруулах, турших, сайжруулах ажлыг ТЗЗҮБ-ийн гишүүн байгууллагуудын оролцоотой хийх
- СБААХ-ын чанарын баталгааг мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачидтай хамтран эцэслэн сайжруулж, ЕБС-ийн менежментэд нэвтрүүлэхэд бэлэн болгох
- ТЗЗҮБ-ийн гишүүдээр дамжуулан төлөөлсөн байгууллагуудад “Ногоон оффис”-ийн стандартыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах
- Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт ТХБ-ын үзэл санаа, агуулгыг интеграцчилах зөвлөмжид үндэслэн интеграцийг хангах чиглэлийг дэмжих академик судалгаа хийх

#### ТХБ-II ТӨСЛИЙН ҮНДЭСНИЙ БАГ



“КОВИД-19 цар тахалтай холбоотой хичээл сургууль хааж буй боловсролын салбарт тохиолдсон үзэгдлийг ЮНЕСКО дан ганц сурлагын хоцрогдол бус сэтгэл санааны хямрал давхцсан “Нэгэн үеийн сүйрэл” хэмээн тодорхойлсон. Энэ хямралаас гарах нь улс орон бүрийн тулгамдсан асуудлын нэг болж байна”.

А. Энхтогтох

\*\*\*

**-КОВИД-19-ын хөл хорионоос үүдэлтэйгээр олонх улс оронд хамгийн их хохирсон бүлэг нь хүүхдүүд гэж үзэж байна. Тэдний боловсрол, хөгжлийн асуудалд ухралт гарлаа ч гэж зарим нь дүгнэсэн. Таны хувьд хэрхэн дүгнэж байна?**

Манай улс хоёр жил гаруйн хугацаанд танхимын сургалтыг хааж зайнаас хичээл сургалтаа явууллаа. Энэ хугацаанд багш нар цахим сургалтын арга зүйд суралцах, сургууль цахим технологийнхоо бэлэн байдлыг хангах асуудал тулгарсан. Тиймээс нийт өрхийн 80 гаруй хувь нь телевизтэй гэсэн 2018 оны судалгаанд үндэслэн хамгийн түрүүнд теле хичээл орох шийдэлд хүрсэн. Энэ бол түр зуурын арга хэмжээ. Хөл хорио удаан хугацаанд үргэлжилсэн тул багш нар зайнаас суралцахтайгаа холбогдож хичээллэх, цахим сургалтыг хөгжүүлэх хэрэгцээ бий болж байна. Энэ хичээлийн жилээс 5-9 гэсэн зарчмаар танхим, цахим хосолсон байдлаар хичээл сургуулийн үйл ажиллагааг явууллаа. Цахимаар орж байгаа хичээлийг үр дүнтэй болгох, багш ярих биш теле хичээлийг үзэж мэдлэг ойлголт авах, бие даан дасгал даалгавар гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх хосолсон сургалтын аргаар зайн ба танхимыг сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх чиглэл өгсөн.

Ер нь зөвхөн КОВИД, халдварт өвчин гэлтгүй бусад шалтгаанаар танхимаар хичээллэх боломжгүй болсон нөхцөлд зайн сургалт явуулах бэлтгэл, бэлэн байдлыг хангасан байх ёстой. Гэвч бодит байдал дээр бүх сургууль интернет холболттой, багш бүр зайн сургалтын технологийг эзэмшсэн үү гэвэл үгүй.

Танхимын хичээл 40 минутаар ордог бол цахим хичээл 20 минутаар орж байна. Энэ нь багш, сурагчийн ачааллыг тооцсон шинжлэх ухааны үндэслэлтэй хугацаа юм. Судлаачдын хийсэн судалгаагаар цахим контентийг анхааралтай үзэх хугацаа нь 6-12 минутад 50-100 хувь төвлөрч оролцоо өндөр байдаг гэсэн дүн байдаг. Түүнээс хойш анхаарал суларч эхэлдэг байна. Тийм учраас цахим хичээлийн хугацааг аль болох бага байх зохицуулалтыг хийсэн. Сургуулиуд багш нарынхаа ачааллыг бууруулах арга хэмжээнүүд авч байгаа. Тухайлбал, нэг багш 6 дугаар ангийн 3 бүлэгт хичээл ордог байлаа гэхэд тухайн гурван бүлэг нэгтгээд цахим хичээлээ орох боломжоор нь хангах, зочил мэргэжлийн багш нарыг ээлжилж оруулах гэх мэт зохицуулалтуудыг хийсэн байна. Бусад улс орнууд ч гэсэн бүх сургууль, багш нар нэг загвараар хосолсон сургалтыг явуулах ёстой гэсэн шаардлагыг тавихгүй байна.

Техник технологийн хувьд хөрөнгө мөнгө шаардсан хүндрэлтэй зүйлүүд бий. Тухайлбал, 2014 онд багш нар өгч байсан компьютер нь өнөөдөр шаардлага хангахгүй болсон. Гэхдээ үүнээс түрүүлээд арга барилын хувьд суралцах зүйлүүд багш, сургуулийн удирдлагуудад байна.

**-Нөгөө талд хүүхдүүд цахим хичээлээ хүлээж авах техникийн нөхцөл тэгш бус байгаа нь ажиглагдсан. Ялангуяа хөдөө малчдын хүүхдүүд цахим хичээлээс хохрох тохиолдол их зарсныг багш нар хэлж байсан.**

Тийм учраас цахимаар хичээл үзэх боломжгүй хүүхдүүдэд танхимаар хичээлдээ явах, сургуулийн нөөц боломжийг ашиглуулах чиглэл өгсөн. Бүгд нэг загвараар хичээл сургалтын үйл ажиллагаа явуулах боломжгүй учраас сургууль бүр тохирсон загвараа сонгон авч ашиглах хэрэгтэй. 2021 оны намар багш нарын онлайн сургалт хийж, хосолсон сургалтын долоон загварыг танилцуулсан. 2021-2022 оны хичээлийн жилийн эхний улиралд сургуулиуд 5-9 зарчмаар хичээллэх явцдаа өөрийн сургуулийн онцлогт тохирох хосолсон сургалтын загварыг сонгож хэрэгжүүлсэн, үр дүнг эхнээс нь харж байгаа байх.

## ЭРЭГТЭЙ ХҮҮХДИЙН СУРГУУЛЬ ЗАВСАРДАЛТ НЭМЭГДЭХ ХАНДЛАГАТАЙ БАЙНА

**-Мэдлэгийг бол нөхөж олгож болно. Харин төлөвшилгүй нөхөх боломжгүй гэж санаа зовох эцэг эх цөөнгүй байна.**

КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор хичээл сургалтын үйл ажиллагааг хааж байгаа боловсролын салбарт

## А.ЭНХТОГТОХ “ӨМНӨХӨӨ ҮГҮЙСГЭДЭГ БУС ОЛОЛТ АМЖИЛТАА УЛАМЖИЛЖ, АВЧ ҮЛДЭХ ШИЙДЛҮҮДЭЭ ГАРГАДАГ БАЙХ НЬ ЧУХАЛ”

**Энэ дугаарын ТХБ-ЗОЧИН БШУЯ-ны харьяа Боловсролын хүрээлэнгийн БХСС-ийн зөвлөх, судлаач, ТХБ-И төслийн Техникийн зөвлөн зохицуулах багын гишүүн А.ЭНХТОГТОХ. Боловсролын салбарт багш, судлаачаар 20 гаруй жил ажиллаж буй туршилагатай мэргэжилтнүүдийн нэг түүнтэй ерөнхий боловсролын анхаарал татсан зарим асуудлаар ярилцлаа.**

тохиолдсон энэхүү үзэгдлийг ЮНЕСКО дан ганц сурлагын хоцрогдол бус сэтгэл санааны хямрал давхцсан “Нэгэн үеийн сүйрэл” хэмээн тодорхойлж байна. Энэ хямралаас гарахын тулд яах ёстой вэ гэдэг бол улс орон бүрийн тулгамдсан асуудлын нэг болж байна. Манай улсын хувьд 2020, 2021 онд ЕБС-ийн сурагчид 56 долоон хоног зайнаас хичээллэсэн. Энэ урт хугацаанд бие даан суралцах арга барил эзэмшсэн хүүхдүүдийн хувьд өөрийн эзэмших мэдлэг мэдээллээ цуглуулаад, багштайгаа эргэн холбогдож баталгаажуулаад явсан. Харамсалтай нь дийлэнх олонх нь бие даан суралцах арга барил эзэмшээгүй учраас хичээлийн хоцрогдол их байх нь ойлгомжтой. Тэгэхээр КОВИД-ын өмнө сурах арга барилын хоцрогдол байсан түүнд дээр удаан хугацаанд зайнаас суралцсан нь бусадтай харилцаж нийгэмшихэд, мөн бие бялдрын хөгжилд нь нөлөөлсөн болохыг судалгааны үр дүнгүүд харуулж байна. Энэ суралцахуйн бэрхшээлээс хэрхэн гарах вэ гэдэг нь зөвхөн манай улсад ч биш бусад улс оронд ч байна.

Тэгэхээр бид хоёрдугаар улирлаас эхлээд хосолсон сургалтын арга барилд түлхүү анхаарах шаардлагатай болж байгаа юм. Багш ангид орсон хичээлээ зайнаас суралцах арга зүйтэй хэрхэн уялдуулах вэ, хүүхдүүд теле хичээлээ хэрхэн үзэх, мэдэхгүй зүйл дээр нь багш хэрхэн туслах вэ, бие даан суралцахуйг хэрхэн удирдан чиглүүлэх вэ гэдэгт багш нараа сургах, бэлтгэх хэрэгтэй байна. Сургуулийн хичээлийн хуваарь, багшийн хичээл заах төлөвлөлт, сурагчийн бие даан суралцах цагийг уялдуулсан замын зураглал тодорхой байх хэрэгтэй. Тэгж байж хүүхэд өөрийн удирдлагатай суралцах, өөрийн хөгжил, төлөвшилд анхаарах цаг гаргах, тэдэнд хөгжих боломжийг бий болгоно.

**-Судалгааны үр дүнгээр хүүхдийн сурлагын хоцрогдол ямар байсан бол?**

Боловсролын үнэлгээний төвөөс хийсэн оношлох үнэлгээгээр ямар хичээлээр агуулгын хэр хоцрогдолтой байгаа талаар эхний үр дүн гарсан байна. Ялангуяа танхимын хичээл ороогүй үеийн хоцрогдол их байгаа нь тодорхой харгадсан. Агуулгын энэ хоцрогдлыг арилгах тал дээр багш нар анхаарах хэрэгтэй.

**-1990-ээд оны нийгмийн шилжилтийн үед сургууль завсардалт маш их байсныг санаж байна. Хүүхэд хэд хонго хичээлдээ явахгүй байхад л сонирхол нь эрс буурдаг, эцэг эхчүүд ч сүүлдээ эвлэрдэг юм шиг надад анзаарагдсан. Тийм эрсдэл үүсээгүй байгаа даа?**

6-14 насныхны болон эрэгтэй хүүхдийн сургууль завсардалт нэмэгдэх хандлагатай боллоо. 2017-2018 оны хичээлийн жилд 682 хүүхэд сургууль завсардсан байсан. Үүнээс 75.4 хувь нь огт сургуульд ороогүй байхад 24.6 хувь нь сургуульд ороод завсардсан гэсэн судалгааны дүн байсан. 2021-2022 оны хичээлийн жилд хийсэн судалгаанаас харахад өмнөх хичээлийн жилээс хойш сургуультайгаа эргэн холбогдоогүй 1794 сурагч, 1-р ангид элсэн суралцаагүй 137 сурагч байна. Үүний 72% нь эрэгтэй, 28% нь эмэгтэй сурагч байна.

**-Сургууль завсардаж болзошгүй эдгээр хүүхэдтэй хэрхэн ажиллах вэ? Бас нас нь болсон ч сургуульд оруулаагүй тохиолдлууд хэр байгаа бол?**

Намар хичээлийн шинэ жил эхлэхэд сургуулиудад үүрэг чиглэл өгсөн. Сургууль завсардаж болзошгүй хүүхдүүдийн ар гэрийг судалж, очиж уулзах сургуульд нь эргэн хамруулах талаар орон нутаг, сургуулийн удирдлага, багш нар анхаарч ажиллах шаардлага гарч байна. Малчин өрхийн хүүхдийг 6 аль эсвэл 7 настай сургуульд оруулж болно. Тиймээс зарим малчид хүүхдээ 7 настай оруулна гээд гэрт нь өнжөөх тохиолдол бий.

## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА ОЛОН УЛСЫН ТҮВШИНД БАЙНА

**-Урлаг, спортын гээд сонирхолтой дугуйлан секцүүд сургуулиуд дээр ажилладаг байсан. Цар тахлын нөхцөл байдлаас болж энэ боломж хаагдсан. Цаашид яах вэ?**

Хүүхдийн авьяасыг нээн хөгжүүлэх нэмэлт сургалт дугуйлангийн үйл ажиллагаа хязгаарлагдсан. Цаашид КОВИД-19-ийн нөхцөл байдал хэрхэн үргэлжлэхээс л хамаарах байх. Ер нь боловсролын тогтолцоонд чөлөөт сонголтын хөтөлбөрүүд байх шаардлагатай болчихоод байгаа юм. Тухайлбал, танхимаар судлах хичээлүүд, хүүхдүүдийн зайлшгүй мэдэх шаардлагатай глобал сэдвүүд, хөгжүүлэх үр чадваруудыг тусгасан байж болно. Тийм сэдвүүдийг хичээл сургалтын агуулгад яаж оруулах вэ, дээрээс нь хүүхэд хөгжүүлэх чөлөөт сонголтын хөтөлбөрүүдийг сургуулиуд хэрхэн хэрэгжүүлэх вэ? Тэр бол зайлшгүй байх ёстой.

**-Сурах бичиг, сургалтын арга барил, хөтөлбөр гэхчлэн ерөнхий боловсролын салбарыг тал талаас нь шүүмжлэх нь их. Таны хувьд ерөнхий боловсролын салбарт цаг адалгүй шийдвэрлэх шаардлагатай ямар асуудал байна гэж үзэж байна?**

-Багшийн заах арга зүй дээр маш их анхаарах шаардлагатай байна. Олон жил ярьж байгаа ч багш төвтэй сургалтын арга барил хэвээрээ л байгаа. Боловсролын хүрээлэнгийн судалгаагаар нийт багш нарын 70 орчим хувь нь уламжлалт багш төвтэй арга барилаар ээлжит хичээлээ зааж байгаа нь гарсан байдаг. Үүнийг өөрчлөхгүйгээр дараагийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломж нөхцөл харагдахгүй байна. Мөн технологийн дэвшилийг сургалтад ашиглах тал дээр багш, сурагчид суралцах шаардлагатай болсон. КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр зайн сургалтад тодорхой ахиц дэвшил гарсан ч цаашид улам сайжруулах, сургууль, багш нарыг тоног төхөөрөмжөөр хангах гээд хойшлуулшгүй асуудал олон. Бид энэ мэт асуудлуудаа шийдэж байж, дараагийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай ярихгүй бол амжилтад хүрэхгүй.

**-Бага ангийн хүүхдүүдийн хичээлийн ачаалал их байна гэж зарим эцэг эхчүүд, судлаач үздэг. Гэтэл зарим хувийн сургуулиудын даалгавар, хичээл улсын сургуулиудынхаас ч их, хүнд байх нь ажиглагддаг юм.**

Манай улсын бага ангийн сурах бичгийн агуулгыг Япон улсын сурах бичгийн агуулгатай харьцуулан судалж үзлээ. Манай улсын хичээлийн агуулга, хөтөлбөрийн хүндрэл, ачаалал бага байна. Жишээлбэл, Япон улсын 6 дугаар ангийн сурах бичигт байгаа хоол боловсруулах эрхтний тогтолцоо гэсэн нэг нэгж хичээлийн агуулгыг манай улсын 6, 7, 8, 9



дугаар ангийн сурах бичигт тусгасан байна. Хүүхдийн маргалтын муруй гэж байдаг. Тийм учраас 6 дугаар ангид үзсэн хичээл дээр нь 7 дугаар ангид нь нэмээд ямар мэдлэг, чадвар эзэмшүүлэх вэ гэдгийг уялдуулж, сургалтын хөтөлбөрийг боловсруулсан онцлог ялгаа байна.

Тэгэхээр бага ангийн агуулга хүнд байна гэдэг судалгааг хаанаас гаргаад ирсэн гэдгийг нь би мэдэхгүй байна. Манай байгууллагын судалж мэдсэнээр хичээлийн агуулга олон улсын түвшинд байна. Гэхдээ багшлах хүний нөөц, сургалтын орчин зэргийг тооцон улс орнуудын сургалтын хөтөлбөрийн агуулгын хүндрэлийн түвшин ялгаатай байж болно. Харин хүүхдэд хэр их ачаалал болж байна вэ гэдэг маань зааж байгаа багшийн арга туршилагаас ихээхэн хамаарна. Хүүхдэд багаж тоног төхөөрөмжтэй ажиллах чадвар эзэмшүүлэх гэж байхад багш тоногт төхөөрөмжийн бүтцийг нэрлэж бичих, зурах даалгавар өгөөд байх нь тохиромжтой бус байгаа биз. Хүүхдийг бие даан сурах арга барилд сургаа гэвэл багш зөв зөвлөн туслагч, чиглүүлэгч байх хэрэгтэй болно. Тэгэхээр багш бэлтгэх тогтолцоогоо эргэж харах шаардлагатай болж байгаа. Дээр нь манай сургалтын орчин, сургуулийн дэд бүтэц олон улсын жишигт хүрсэн үү гэвэл үгүй. Мөн хамран сургах тойрог гэдэг зүйлээ барихгүй байгаатай холбоотойгоор нийслэлийн төвийн сургуулиудын ачаалал хэрээс хэтэрсэн гэдгийг хүн бүр анзаарч байгаа. 25 хүүхэдтэй ажиллах ёстой багш 50 хүүхэдтэй ажиллахаар яах вэ. Дунд сургуулиудад зэрэглэл бий болчихоод байгаа нь ачаалал хэрээс хэтрэх нэг шалтгаан болоод байна.

## ДУНД СУРГУУЛИУДАД ЗЭРЭГЛЭЛ БИЙ БОЛЧИХООД БАЙГАА НЬ АЧААЛАЛ ХЭРЭЭС ХЭТРЭХ ШАЛТГААН БОЛООД БАЙНА

**-Аль ч салбарт шийдвэр гаргахдаа шинжлэх ухаанч судалгаа нотолгоог дуржин болгодог, болгох ч ёстой байх. Боловсролын салбарт энэ судалгаа шинжлэгийг хийж таниулах үүрэгтэй ямар байгууллагууд байна?**

Манай БШУЯ-ны харьяа Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын үнэлгээний төв гэсэн гурван мэргэжлийн байгууллага ажиллаж байна. Боловсролын хүрээлэн боловсролын чиг хандлага, сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг судлах зэрэг чиг үүрэгтэй. Тодруулбал, өмнө хэрэгжүүлсэн сургалтын хөтөлбөрийн үндэсний үр дүн, нийгмийн эрэлт, суралцагчийн хэрэгцээ юу байна вэ гэдгийг илрүүлэх судалгаа хийнэ. Цаашлаад дээрх хэрэгцээ шаардлагуудад нийцсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулах үндэслэлийг гаргана. Мөн сургууль дээр сургалтын хөтөлбөр хэрхэн хэрэгжиж байгааг судалж үздэг.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт судалгаанд үндэслэн багшийг давтан бэлтгэх үүрэгтэй.

Боловсролын үнэлгээний төвийн тухай сургалтын хөтөлбөр хэрэгжүүлснээр хүүхдэд ямар ахиц дэвшил бий болох гэдгийг тандан судлах үүрэгтэй. Шинэ сургалтын хөтөлбөр хэрэгжсэнээр хүүхдүүдэд ямар ахиц дэвшил гарч, ямар үзүүлэлтүүд буурч байгааг судалдаг. Энэ гурван байгууллагаас гаргаж байгаа судалгаа мэдээлэлд үндэслэн өнөөдөр хэрэгжиж байгаа сургалтын хөтөлбөрийг үндэслэн, шинэ сургалтын хөтөлбөрийг боловсруулах үндэслэл, чиглэл тодорхой болно гэсэн үг. Боловсрол өөрөө судалгаа нотолгоонд суурилсан байдлаар хөгжино гэхээр мэргэжлийн институтынхээ үгийг сонсдог, тухайн байгууллагуудын судалгааны үр дүнг хэлэлцдэг, алдаа оноогоо дүгнэдэг, өмнөхөө үгүйсгэдэг бус ололт амжилтаа уламжилж, авч үлдэх шийдлүүдээ гаргадаг байх нь чухал юм. Өнөөдөр яг ийм судалгаа тооцоог хийж байгаа эрдэмтэн судлаачид маань хэд байгаа билээ, үр чадвар нь ямар байгаа билээ гээд хүний нөөцийн хувьд дутагдалтай гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

## СУРГУУЛЬ ТХБ-ЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ ТӨВ БАЙХ ЁСТОЙ

**-Тогтвортой хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролыг олгох нэг үр дүнтэй суваг нь сургууль гэж харж байна. Чухам яаж, ямар арга хэлбэрийг ашиглаж байна вэ?**

Сургууль ТХБ-ыг түгээн дэлгэрүүлэх төв байх ёстой. Дэлхийн улс орнууд ТХБ-ыг сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйд тусган хэрэгжүүлж байна. Түүнийг түгээн дэлгэрүүлэх төв бол сургууль байх гэдэгтэй санал нэг байна.

**-ТХБ өөрөө ямар иргэний, ямар нийгмийг, ямар дэлхийг бүтээхэд чиглэж байна?**

Бид бүгд “дэлхий” гэдэг нэг гэрт амьдарч байгаа. Тэгэхээр гэр орноо арчлах, эмх цэгцтэй, арвич хямгац, цэвэр цэмцгэр амьдрах нь гэр бүлийн гишүүдийн үүрэг байдагтай адил дэлхийн хүн төрөлхтөн бүр байгаль дэлхийгээ хайрлах, хүн төрөлхтөний сайн сайхны төлөө үүрэг хариуцлагаа ухамсарлан, эдийн засгийн хувьд хэмнэлттэй амьдрахыг чухалчлах хэрэгтэй байгаа тул хүүхэд залуучуудад бага наснаас нь ТХБ-ыг хичээл, сургалтын үйл ажиллагаагаар эзэмшүүлэх нь чухал гэж бодож байна.

-Баярлалаа.



**ТХБ-II төслийн Техникийн зөвлөн  
зохицуулах үндэсний багийн гишүүн-  
НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ МЭДЭЭЛЖ БАЙНА.**

**БИДНИЙ ТУХАЙ**



Монгол улсын төрөөс иргэдийнхээ насан туршид сурч хөгжих хэрэгцээг албан болон албан бус боловсролын нэгдлийг боловсронгуй болгох замаар хангана гэж үзээд Боловсролын тухай хуулинд “Монгол Улсын боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байна”, “Иргэн нь боловсролыг албан болон албан бус сургалтаар эзэмшиж болно” гэж хуульчлан заасан байдаг.

Албан бус хэлбэрээр эзэмших насан туршийн тасралтгүй боловсрол нь боловсрол эзэмших иргэний эрхийн салшгүй хэсэг бөгөөд нийгэм-соёлын тэгш бус байдлаас үүдэлтэй хүн бүрийн ялгаатай хэрэгцээг хангах, мэдлэгт суурилсан нийгмийг цогцлоон байгуулах үйл ажиллагаа, цаашлаад хүмүүс хэрэгцээт мэдлэг, чадвар, хандлагын үнэт зүйлсийг эзэмших, өөрийн бололцоонд тулгуурлан амьдралаа зөв авч явах, амьдралын чанараа дээшлүүлэх гол хэрэгсэл юм.

**Эрхэм зорилго:** Хүн төрсөн цагаасаа эхлэн насан хугтгийг олох хүртлээ амар тайван, эрүүл энх, нэр төртэй амьдрах орчинг бүрдүүлэх насан туршидаа тасралтгүй боловсрох боломжийг бүрдүүлэх.

**Үйл ажиллагаа:**

- Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх насан туршийн боловсролын бодлого боловсруулахад БШУЯ-ыг мэдээллээр хангах,
- Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аймаг, сум, дүүргийн Насан туршийн боловсролын төв, нэгжийг арга зүй, удирдлагаар хангах,
- Насан туршийн боловсролын салбарын багш, боловсон хүчнийн мэргэшүүлэх, ур чадвар дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах,
- Иргэдийн сурах хэрэгцээний судалгаа хийх,
- Иргэдэд зориулсан танхимын, танхимын бус, бие даан сурах, зайнаас болон онлайн сургалтад хэрэглэх ном, сурах бичиг, сургалтын материал, хөтөлбөр боловсруулах,
- Зайны сургалтын хэвлэмэл, цахим, аудио, видео материал бэлтгэх, хэвлэх,
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернэт орчинд зориулагдсан материал боловсруулах


**Салбар дундын хамтын ажиллагаа:**

БОАЖЯ, НХХЯ, ЭМЯ, БХЯ, ХЗЯ, Сангийн яам, Монголбанк төрийн зарим байгууллагатай үндэсний хөтөлбөр боловсруулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах, гарын авлага боловсруулах зэргээр хамтран ажиллаж байна.

**Гадаад хамтын ажиллагаа:** НУБ-ын төрөлжсөн байгууллага болох ЮНЕСКО, ЮНИСЕФ, Хүн амын сан, Японы Хүүхдийг Ивээх сан, ЖАЙКА, Швейцарын хөгжлийн агентлаг, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг зэрэг олон улсын байгууллагатай хамтран ажиллаж тодорхой үр дүнд хүрсээр байна.

**НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН  
355 ТӨВ АЖИЛЛАЖ БАЙНА**

2021 оны байдлаар улсын хэмжээнд насан туршийн боловсролын 355 төв үйл ажиллагаа явуулж байгаагаас 29 төв бие даасан хэлбэрээр, 326 төв орон нутагт ерөнхий боловсролын сургууль эсвэл сумын Засаг даргын тамгын газрын харьяанд ажиллаж байна. Насан туршийн боловсролын салбарт нийт 683 боловсон хүчин ажиллаж байгаагийн 525 нь насан туршийн боловсролын багш байна.



**МАЛЧДЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ ӨРГӨЖҮҮЛЭХ  
ДЭД ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ**



Насан туршийн боловсролын үндэсний төв /НТБҮТ/ малчин иргэдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендэр, харилцааны ур чадвар, нийгмийн даатгалын ач холбогдлын талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, тэдний амьдрах ухааны чадварыг дэмжих, малчдын хоршооны засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн “Малчдын амьдрах ухааны чадварыг дэмжих, нийгмийн хамгааллыг өргөжүүлэх дэд хөтөлбөр”-ийг ОУ-ын хөдөлмөрийн байгууллага, НУБ-ын ХАС-тай хамтран хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрийн хүрээнд малчдын амьдрах ухааны чадварыг дээшлүүлэх, өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, малчдын нийгмийн даатгалын ач тус болон хоршооны тухай мэдлэг ойлголтод дэмжлэг үзүүлэх сургалтыг Хэнтий аймагт зохион байгуулж, арга зүйн зөвлөмж боловсрууллаа.

Энэ тухай НТБҮТ-ийн хэлтсийн дарга С.Амарсайхан ярихдаа “Малчдын эрүүл мэнд, боловсролд хөрөнгө оруулснаар залуучуудын нийгмийн оролцоо, сайн сайхан байдлыг хангаж, нөөц бололцоогоо бүрэн дайчлахад нь туслаад зогсохгүй нийгмийн эрүүл мэнд, жендэрийн тэгш байдлыг сайжруулахад чухал ач холбогдолтой. Энэ цаг үед малчин иргэн санхүүгийн хувьд биеэ даасан, өрхийн орлогоо нэмэгдүүлсэн хамтран хоршиж ажиллахын ач холбогдлыг ойлгосон иргэн байхад нь дэмжлэг үзүүлэх, тэдний нийгмийн даатгалд хамрагдалтын хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор бид хамтран ажиллаж байна” гэлээ.

Мөн эрүүл мэнд, бэлгийн цогц боловсрол олгох жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох, нөхөн үржихүй, харилцааны ур чадваруудыг хөгжүүлэх чиглэлийн сургалтыг зарим аймгийн малчны хотонд зохион байгууллаа.

**МАЛЧДЫН АМЬДРАХ УХААНЫ ЧАДВАРЫГ  
ДЭЭШЛҮҮЛЭХ “ҮНДЭСНИЙ СУРГАГЧ БАГШ”  
НАРЫГ БЭЛТГЭЖ БАЙНА**

“Малчдын амьдрах ухааны чадварыг дэмжих, нийгмийн хамгааллыг өргөжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хүрээнд Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай үндэсний сургагч багш нарыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх сургалтыг Улаанбаатар хотод энэ сард зохион байгууллаа. Сургалтад хамрагдсан багш нарт “Үндэсний сургагч багш” гэрчилгээ гардуулав.



“Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр”-т малчин залууст аж ахуй эрхлэх, мал маллах уламжлалт арга барил эзэмшүүлэх, амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн мэдлэг, чадвар, чадамжийг хөгжүүлэх, насан туршийн боловсролын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах гэж заасан байдаг. Өнөөдөр малчин залуусын эрүүл мэнд, сайн сайхан амьдрах чадавхыг дээд зэргээр дэмжихийн тулд нийгмийн зүгээс малчдад хийх оюуны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь туйлын чухал болоод байгааг НТБҮТ-ийн удирдлагууд мэдэгдэж байсан юм.

Манай улс 300 мянга гаруй малчинтай. Тэд улсын нийт ажиллах хүчний 30 хувийг бүрдүүлж байна.



НУБ-ын төрөлжсөн байгууллагуудтай хамтарсан “Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд харуу үзүүлэх бэлэн байдлыг нэмэгдүүлэх нь” төсөл Завхан аймагт хэрэгжиж байна.

**Л.БОЛОРТУНГАЛАГ: НАСАН ТУРШИЙН  
БОЛОВСРОЛД НАСНЫ ХЯЗГААР ГЭЖ ҮГҮЙ**

*Иргэд, олон нийтэд тогтвортой хөгжлийг боловсролоор дамжуулан хүргэх нь илүү ач холбогдолтой.*



*Насан туршийн боловсролын үндэсний төвийн захирал Л.Болортунгалагтай ярилцлаа.*

**-Насан туршийн боловсрол гэж юуг хэлэхээс яриагаа эхлэх үү?**

Дэлхий нийтийн боловсролын чиг хандлагаар насан туршийн боловсрол гэж албан болон албан бус боловсрол, амьдралаас суралцахуйг багтаан томъёолж байна. Энгийнээр тайлбарлавал хүн эхийн урагт бүрэлдэхээс эхлэн насан хугтгийг олох хүртэлх бүхий л хугацаандаа хөгжиж, боловсорч байдаг. Манай улсын хувьд иргэд 3 наснаас буюу сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон дээд боловсрол, магистр, докторын зэрэг хамгаалах гээд албан боловсролд ойролцоогоор 30 нас хүртэл суралцаж байна.Тэгвэл хүн 100 хүртэл насална гэвэл үлдсэн 70 жилд суралцах, хөгжих асуудал яригдана.

Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага ч хүний хөгжил, насан туршид суралцахуйд чиглэж, амьдралаас суралцах, тасралтгүй хөгжих үйл явцыг хүлээн зөвшөөрч баталгаажуулахыг чухалчлан үзэж байна.

Манай улс үүнд анхаарлаа хандуулж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр “Алсын хараа 2050”-даа Хүний хөгжлийг үндсэн тулгуур гэж тодорхойлсон.

**-Насан туршийн боловсролд хүн бүр хамрагдах боломж бий юу?**

Хувьсан өөрчлөгдөж буй мэдээллийн технологийн хурдацтай, хөгжлийн эрин үед иргэд тухайн нийгмийн хөгжлөөс хоцрохгүйн тулд, амьдралын чанараа дээшлүүлэхийн тулд нийгмийн орчинд идэвхтэй оролцох, ажлын шинэ шинэ боломжуудыг ашиглах, мэдлэг, чадвараа хөгжүүлэх, суралцах шаардлага байгаа үүсч байгаа. КОВИД-19 цар тахлын энэ үед бид өчнөөн сорилтуудтай тулгарлаа. Наад зах нь үсчинд орохгүйгээр гэр бүлийнхнийхээ үсийг засч сурах хэрэгтэй боллоо. Мөн бүх үйл ажиллагаа цахимгаар явагдах болсноор бид мэдээлэл технологи, дижитал ур чадвараа сайжруулах хэрэгцээ улам нэмэгдэж байгааг мэдэрлээ. Яг ийм байдлаар насан туршид суралцахуйн үйл ажиллагаа нь бүх хүн амд хамааралтай бөгөөд аль нэг зорилтот бүлгээр хязгаарлагдахгүй.

Иргэдэд насан туршийн боловсролын төвүүд нээлттэй, боломжтой.

Хамгийн гол нь иргэд суралцахуйд суралцах буюу тасралтгүй суралцах сэдэл тэмүүлэл, эрмэлзэлтэй байж, өөрийн хэрэгцээ, нөхцөл байдлыг ухаарсан байх нь чухал. Бас нэг чухал нь амьдралаас суралцахуй. Хүн өдөр тутмын амьдралаасаа гэр бүлдээ, хамт олондоо, ажлын байрандаа ч суралцаад явж байдаг.

Хүн өөрийн туулсан амьдралаас суралцах нь илүү үр дүнтэй арга болохыг дэлхий нийт онцлох болсон. Монгол Улсын насан туршийн боловсролын бодлого эрх зүй, санхүүжилтын хувьд дэлхийн жишигт хүрч чадахгүй байгаа ч тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд боловсролын чанарыг сайжруулах, тэгш боломж олгох, харилцан уялдаатай хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, иргэн бүрт хүрч үйлчлэх хэрэгцээ шаардлагыг харгалзан өргөн хүрээтэй оролцоог идэвхжүүлэхийг зорьж байна.

Боловсролын хуулинд насан туршидаа суралцахуйн асуудлыг цогцоор нь тусгана. Мөн насан туршидаа суралцахуйн стратеги, хөтөлбөртэй болвол бид насан туршидаа суралцах боломжоор хангагдаж, хэн ч, хэзээ ч, хаанаас ч суралцах боломж бүрдэх юм.

**-Тогтвортой хөгжлийн боловсролын зорилттой насан туршийн боловсрол хэрхэн уялдаж вэ?**

-Иргэд, олон нийтэд тогтвортой хөгжлийг боловсролоор дамжуулан хүргэх нь илүү ач холбогдолтой бөгөөд Тогтвортой хөгжлийн боловсрол нь насан туршийн боловсролын бүхий л хэлбэрүүдэд хэрэгжиж байдаг.

“Тогтвортой хөгжил 2030”-н уриалга бол “Хэний ч ардаа үлдэхгүй, хамтдаа хөгжих” мөн “иргэн бүрийн оролцоо чухал” -г онцолж байгаа.

Иргэн бүр тогтвортой хөгжлийн талаар тодорхой ойлголттой байж гэмээнэ хувь хүн, гэр бүл, улс орон хөгжинө. Насан туршийн боловсролын төвүүдээр дамжуулан Монгол Улсын нийт иргэдэд, олон нийтэд насан туршидаа суралцахуй болон Тогтвортой хөгжлийн боловсролыг эзэмшүүлэхэд удирдлага, арга зүй, менежментээр ханган ажиллаж байна.

Монгол Улсад БШУЯ, БОАЖЯ, Швейцарын хөгжлийн агентлагын хамтран хэрэгжүүлж байгаа Тогтвортой хөгжлийн боловсрол-II төсөлд Боловсролын хүрээлэн, Насан туршийн боловсролын үндэсний төв, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Монгол улсын боловсролын их сургууль зэрэг 11 байгууллага техникийн зөвлөн туслах баг болон хамтран ажиллаж байна. Энэхүү төслийн хүрээнд өнгөрсөн 5-р сард “Тогтвортой хөгжлийн боловсролын төлөөх хамтын санаачилга, түншлэл” нэгдсэн виртуал хамгийн олон оролцогчтой том чуулганыг үндэсний хэмжээнд цахимгаар зохион байгуулсан. Үр дүн ч маш өндөр байсан.

**Баярлалаа.**

**ТХБ-II төслийн Техникийн зөвлөн зохицуулах багийн гишүүн-ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВ МЭДЭЭЛЖ БАЙНА**

**МЭДЭЭ**

**АВТОБУСТАЙ ҮЗЭСГЭЛЭН, СУРГАЛТ АГААР ОРЧНЫ БОХИРДЛЫГ ТАНИУЛЛАА**

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн сургагч багш нар энэ оны 9, 10-р сард “Агаар орчны бохирдол хүүхдэд” сэдэвт автобустай үзэсгэлэн, сургалтыг Баянхонгор, Говь-Алтай, Өмнөговь аймаг, нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн 2055 сурагчдын дунд зохион байгууллаа.



НУБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэй тус үйл ажиллагаа нь тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд агаар орчны бохирдол, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулахад хүн бүрийн оролцоо чухал болохыг таниулах, эко клубын сурагчдын оролцоог идэвхжүүлэх, сургуулийн орчинг эрүүл, аюулгүй хүүхдэд ээлтэй байлгах зорилготой байсан юм. Шинэлэг хэлбэрээр зохион байгуулсан тус үйл ажиллагаа хүүхдүүдийг сонирхлыг ихээр татаж байлаа.

\*\*\*

**“АГААР НЭГ” ВИРТУАЛ 360 ИНТЕРАКТИВ БҮТЭЭЛ ГАРГАЛАА**

НУБ-ын Хүүхдийн сан, Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв /ЦУНБХТ/ хүүхэд залууст зориулсан “Агаар нэг” виртуал 360 интерактив контент бүтээлээ. Энэхүү виртуал 360 интерактив контент 360 орчноор дамжуулан хүүхэд, залууст хүрээлэн буй орчны тухай цогц мэдээллийг олгох, веб дизайн руу чиглэсэн шинэлэг байдлаар олон нийттэй харьцах арга замыг хайх зорилгоор бүтээсэн юм.



ЦУНХТ нь цахим сүлжээ ашиглан бүх нийтэд байгаль орчны боловсрол олгох цахим хичээл, видео болон аудио подкаст, цахим хөтөч зэрэг төрлийн видео контент, инфографик танин мэдэхүйн мэдээ мэдээллийг тогтмол хүргэдэг.

Тэгвэл 360 виртуал орчин гэдэг нь дээрх мэдээ мэдээллүүдийг нэгтгэн, “интерактив” байдлаар цогцлоон хүргэх шинэ боломжийг нээж өгч байгаагаараа онцлогтой.

“Агаар нэг” Виртуал 360 интерактив контентод агаарын бохирдол болон агаарын бохирдлоос хэрхэн хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээлэл багтсан. Виртуал орчинд зочлон аялангаа, мэдээллээ авараар.

Энэхүү хаягаар нэвтрээрэй. [https://uptech.mn/vr\\_projects/AireditedV/index.htm?fbclid=IwARIYP-jKCSF4LndJIS8cSANVO\\_7uzk3cqE5tUFWxndIQ-b9u9Kk9rN-DBwKw](https://uptech.mn/vr_projects/AireditedV/index.htm?fbclid=IwARIYP-jKCSF4LndJIS8cSANVO_7uzk3cqE5tUFWxndIQ-b9u9Kk9rN-DBwKw)

\*\*\*

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАГЧДЫН ДУНД “ТАНД ХҮРГЭХ БИДНИЙ ҮГ” ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ**

ЦУНБХТ, НУБ-ын Хүүхдийн сан, Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр “Танд хүргэх бидний үг” төслийн ерөнхий боловсролын сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын дуу хоолойг нийгэмд хүргэх, тэдний агаар, орчны бохирдлын талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлэв.

Хөгжлийн бэрхшээлтэй сурагчид нийгмийн харилцаанд оролцоходоо хэн нэгнээс тусламж авах, тэднээр дамжуулан мэдээллийг хүлээн авах шаардлага тулгарч байгаа юм. Иймд хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад сургууль, багш, эцэг эх, гэр бүлийн гишүүдээр дамжуулахгүй өөрсдөө мэдээ

мэдээлэл олж авах боломжоор хангагдах, улмаар нийгэмд үе тэнгийнхэнтэйгээ хөл нийлүүлэн алхах боломж олгох нь урамших, бахархах сэдэл төрүүлэх сайн талтай.

“Танд хүргэх бидний үг” төслийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын дуу хоолойг нийгэмд хүргэх, тэдний “Агаар, орчны бохирдол”-ын мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх зорилготойгоор дунд ангийн сурагчдын дунд “Агаарын бохирдол” гар зургийн уралдаан, ахлах ангийн сурагчдын дунд “Агаарын бохирдлын өнгө-Бидний амьдрал” сэдэвт гэрэл зургийн уралдааныг тус бүр зохион байгуулсан. Уралдаанд хөгжлийн бэрхшээлтэй сурагчдаас 61 бүтээл ирснээс:



**“Агаарын бохирдол” сэдэвт гар зургийн уралдаанд:**

1. Тэргүүн байр: Нийслэлийн 29 дүгээр сургуулийн 9А ангийн сурагч Б.Сэргэлэн;
2. Дэд байр: Нийслэлийн 29 дүгээр сургуулийн 6Б ангийн сурагч Х.Энхсаран;
3. Гутгаар байр: Нийслэлийн 29 дүгээр сургуулийн 6А ангийн сурагч Д.Энхмэнд нар тус бүр шалгарлаа.

**“Агаарын бохирдлын өнгө бидний амьдрал” сэдэвт гэрэл зургийн уралдаанд:**

1. Тэргүүн байр: Нийслэлийн 29 дүгээр сургуулийн 10Б ангийн сурагч Э.Оюундарь;
2. Дэд байр: Нийслэлийн 29 дүгээр сургуулийн 11Б ангийн сурагч Г.Мөнхбадрал;
3. Гутгаар байр: Нийслэлийн 29 дүгээр сургуулийн 11А ангийн сурагч Б.Уранцэцэг нар шалгарлаа.

**ХОГ ХАЯГДЛЫГ ЭХ ҮҮСВЭР ДЭЭР НЬ БУУРУУЛЖ, АНГИЛАН ЯЛГАЖ СУРАХ НЬ ЧУХАЛ**

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь “Тогтвортой байдлын зөвлөл”-ийг байгуулж, төвийн албан хаагчид болон төвийн байранд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад таниулан сурталчлах ажлыг зохион байгуулж байна. Үүнд:

1. Төвийн албан хаагчид болон төв дээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад хог хаягдлын менежментийн талаарх сургалтыг зохион байгуулж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах мэдлэг ойлголтыг олгох;
2. Төвийн давхар бүрт ангилан ялгах хогийн савнуудыг байршуулах;
3. Төвийн гаднах талбайд зориулалтын ангилан ялгах хогийн цогийг байршуулах;

**ТАНИЦУУЛГА**

**ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВИЙН ТҮҮХЭЭС**

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТУГ нь 2011 оны 11 дүгээр сарын 09-нд байгуулагдсан.

Манай төв нь 4 үндсэн чиглэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

1. Бүх нийтэд Экологийн боловсрол олгох сургалт зохион байгуулах
2. Цэнгэг усны нөөц болон бусад байгалийн нөөц баялгийг хамгаалах
3. Судалгаа шинжилгээний ажил эрхлэх
4. Байгаль орчны талаарх мэдээлэл сурталчилгааны ажил зохион байгуулах

Бид бүх нийтэд экологийн боловсрол олгох зорилтынхоо хүрээнд Монгол орны усны нөөц, түүний ашиглалт, хэрэглээ, тогтвортой хөгжлийн боловсрол, биологийн олон янз байдал, байгалийн нөөцийн менежмент, байгаль орчны бохирдол, доройтол зэрэг агуулгын хүрээнд 200,000 гаруй хүнд танин мэдэхүйн мэдлэг ойлголтыг олгох сургалтыг зохион байгуулаад байна.

Манай төв нь СӨБ, ЕБС, Их дээд сургууль, аж ахуйн нэгж байгууллага, ард иргэд гээд бүх насныханд зориулсан байгаль орчныг хамгаалах, олон нийтэд байгаль орчны мэдлэг ойлголтыг олгох, зөв дадал хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг тогтмол явуулж байна.

Мөн салбарын ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах, салбарын хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг олон нийтэд сурталчлах үйл ажиллагааг тасралтгүй явуулж ирлээ.

**АМЖИЛТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭСН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДЭЭС**



Манай төв нь олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн хамтын ажиллагааны хүрээнд өнөөдрийг хүртэлх хугацаанд 20 гаруй төсөл хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлээд байна.

- **Бидний хийж хэрэгжүүлсэн ажлаас:**
- Улсын хэмжээнд байгаль хамгаалах үйлсэд хүүхэд залуусын оролцоог нэмэгдүүлэх, байгаль хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулах зорилго бүхий “Ногоон паспорт” аяныг 2018 оноос эхэлж 150,000 гаруй сурагчийг хамруулан байгаль орчноо хайрлан хамгаалах зөв дадал, зөв хандлагыг төлөвшүүлэхэд уриалсан 40 гаруй үйл ажиллагааг зохион байгуулжээ.
- “Ногоон паспорт-Ногоон төгөл” аяныг 21 аймаг, 9 дүүрэгт амжилттай зохион байгуулж 15,000 мянга орчим мод бут тарьсан байна. Цаашид мод тарих, мод үржүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэхээр ажиллаж байна.

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь шинжлэх ухааны үндэслэлтэй, бодит үр дүнд суурилсан мэдлэг, чадвар, хандлага үнэт зүйлсийг бүх нийтэд бий болгох замаар байгаль орчин, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалахыг эрхэм зорилго болгон ирээдүйд Олон улсын жишигт нийцсэн байгаль орчны сургалт, судалгаа, мэдээллийн төв болохоор зорин ажиллаж байна.

\*\*\*

**ЯРИЦЬЯ**

**УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨГ БУУРУУЛАХАД ХҮН БҮРИЙН ОРОЛЦОО ЧУХАЛ**

*ТХБ-БИД булангийн зочин Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн захирал Ч.БАТСАНСАР:*

**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ-II ТӨСЛИЙН ҮНДЭСНИЙ БАГИЙН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙД**



Манай байгууллага нь 2016 оноос Тогтвортой хөгжлийн боловсрол-I төсөлтэй хамтран ажиллаж ирсэн. 2016-2017 онуудад Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалгаар Швейцарын хөгжлийн агентлагийн “Тогтвортой хөгжлийн боловсрол-I” төслийн дэмжлэгтэйгээр тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг байгаль орчны салбарын ажилтан, албан хаагчид болон шийдвэр гаргах түвшинд ойлгуулах, дэлгэрүүлэх, улс эх орноо цаашид тогтвортой хөгжлийн замаар хөгжүүлэхэд олон нийтийн хандлагыг бий болгох, салбарын ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах зорилготой “Тогтвортой хөгжил, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсрол”, “Төсөл бичих арга зүй” сургалтын төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн. 2020 оноос Тогтвортой хөгжлийн боловсрол-II төслийн техникийн зөвлөн зохицуулах үндэсний багийн гишүүн байгууллагаар ажиллаж байна. Тогтвортой хөгжлийн боловсрол-II гишүүн байгууллагын хувьд дэлхий нийтээрээ 2030 онд хүрэхээр төвлөсөн ТХЗ-уудын биелэлтэд болон Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, “ТХБ-II” төслийн хэрэгжилтэд тус тус бодитой хувь нэмэр оруулахын тулд хүүхэд, залуучуудын ТХБ-ын төлөөх оролцоог нэмэгдүүлэх, үзэл бодол, дуу хоолойгоо эрх тэгш чөлөөтэй илэрхийлэх боломжийг бүрдүүлэх замаар тэдний идэвх санаачилгыг дэмжих, улмаар тогтвортой хөгжил, тогтвортой хөгжлийн зорилт, тогтвортой хөгжлийн боловсролын төлөөх хөтөлбөр, төслүүдийг уялдуулж, тэдгээрийн үр өгөөжтэй, тогтвортой түншлэх боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

**БИДНИЙ 2021 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭС**

Бид энэ онд Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын тархалттай холбоотойгоор сургалт, сурталчилгаа, үйл ажиллагаагаа илүү цахим хэлбэрт шилжүүлэн ажиллалаа. Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн хүрээнд зохион байгуулсан Үндэсний хэмжээний виртуал арга хэмжээнд “Өсвөр үеийнхний дуу хоолой-Байгаль орчны залуу сурвалжлагч” форумыг цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулан ажилласан. Эндээс үзэхэд цахим хэлбэрээр үйл ажиллагаа зохион байгуулахад төсөв хөрөнгө, цаг хугацаа хэмнэсэн зэрэг давуу талууд олон байгаа нь ажиглагдсан. Мөн бид тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санаа, ойлголт мэдлэгийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах зорилгоор өөрийн байгууллагын үйл ажиллагаанд Ногоон оффисийн менежментийг нэвтрүүлж эхлээд байна.

Манай байгууллага нь байгаль орчин, аялал жуулчлалын салбарын 2021-2024 оны стратегийн төлөвлөгөө, салбарын 36 хууль, үүнээс голлох 12 хууль, 15 үндэсний хөтөлбөр, олон улсын гэрээ конвенцтой нийцүүлэн байгууллагын стратегийн төлөвлөгөөг боловсруулсан.

**БИД 120 МЯНГАН СУУЛГАЦ ТАРЬЖ УРГУУЛНА**

Манай байгууллага Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан 1 тэрбум мод тарьж ургуулах үндэсний хөдөлгөөнийг дэмжин нийт 120.000 мод тарьж ургуулахаар төлөвлөдөг байна. Бид Япон улсын элчин сайдын яам болон аж ахуй нэгжүүдтэй хамтран Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт байгуулах судалгааны полигондоо мод үржүүлгийн талбай байгуулахаар бэлтгэлээ хангаж байна. Мөн өөрсдийн нөөц бололцоондоо түшиглэн шилмүүст мод үрсэлж бойжуулан жил бүр 20.000 модны тарьц суулгац ургуулахаар төлөвлөсөн. Иргэд, олон нийт та бүхнийг ч гэсэн бидэнтэй бүх талаар хамтран ажиллахыг урьж байна.

Ирж буй шинэ оноо аз жаргал, амжилт бүтээлээр дүүрэн угтаарай.

ТХБ-II төслийн түшиц сургуулиудын зурав нь нийслэлийн Баянгол дүүргийнх. Тус дүүрэг “Баянгол-Цахим сургууль” хөтөлбөрийнхөө хүрээнд “Шинэ эхлэл”, “Эрдмийн өргөө” болон 28 дугаар ерөнхий боловсролын сургуулийн амжилттай хэрэгжүүлж байгаа Тогтвортой хөгжлийн боловсролын төслүүдийг судлан, сайн туршилагыг дүүргэтээ нутагшуулж, түгээн дэлгэрүүлэхээр ажиллаж байна.

ТХБ-УЛААНБААТАР буланг нийслэлийн БАЯНГОЛ дүүргээс бэлтгэлээ.

**ЯРИЛЦА**

**Д.ЖАРГАЛСҮРЭН “ТХБ ТӨСӨЛ САЙН ТУРШЛАГЫГ СУДЛАХ, НУТАГШУУЛАХ БОЛОМЖ ОЛГОЖ БАЙНА”**

*“Бид дүүргийнхээ боловсролын чанар, хүртээмжийг ахисан түвшинд гаргахын тулд сайн туршилагыг судалж, хамтдаа хэрэгжүүлэхийг зорьж байна. Бидэнд яг ингэж түншилж, хамтарч ажиллах хэрэгцээ шаардлага ч тулгарч байна”*

*“ТХБ-II Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын орлогч, ТХБ-II төслийн ТЗОН-ын багийн ахлагч Д.Жаргалсүрэнтий ярилцлаа.”*



ТХБ-II төслийн бичил төсөл Нийслэлийн Баянгол дүүргийн 28 дугаар сургууль, “Эрдмийн өргөө” цогцолбор сургууль болон Олон улсын хөтөлбөрт сургалттай “Шинэ эхлэл” сургууль гээд гурван ерөнхий боловсролын сургууль дээр амжилттай хэрэгжиж байна. Энэ төслийн зорилго болон сонгогдсон сургуулиудын санаачлан хэрэгжүүлж буй жижиг төслийн санал санаачлага нь бидний хэрэгжүүлж байгаа “Баянгол-Цахим сургууль” хөтөлбөртэй нийцж байгаа

учраас ТХБ-II төслийн сайн туршилагыг судлах, авч хэрэгжүүлж, нутагшуулах боломж бидэнд бий болж байна.

Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан цахим сургалт зохион байгуулах, сургууль эцэг эх, сурагчдын харилцааг цахимжуулах зорилтын хүрээнд манай дүүрэг “Баянгол-Цахим сургууль” хөтөлбөрийг боловсруулан улсын төсвийн 2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар шаардлагатай тоног төхөөрөмж хэрэгжүүлдэгдэхээр сургуулиудаа хангахаар ажиллаж байна. Энэ хөтөлбөр үндсэндээ суралцагчдад сургалтын тэгш боломж олгохоос гадна танхимын болон цахим хосолсон сургалт явуулах боломжийг бүрдүүлэхээр зорьж байгаа юм.

*“Чухам ямар боломж болоцоог бий олгоно гэж тооцож байна?”*

Энэ хөтөлбөрийн хүрээнд багш, сурагч, эцэг эхчүүдийн харилцааг цахимжуулах, сургалтын ялгаатай байдлыг арилгах зорилгоор ERP системийг хөгжүүлж байна. Эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ хичээлийн агуулга, явцыг цахимаар хянаж, санал хүсэлтээ илэрхийлэх бололцоотой болно. Мөн хичээл сургалтын үндсэн судлагдахуун агуулгыг судлахаас гадна багш нар гүнзгийрүүлсэн сургалттай, лаборатори сургуулиудын хичээлийн агуулгыг “Цахим сургууль”-аас авах, судлах боломжийг олгож байгаагаараа давуу талтай.

Бид “Цахим сургууль” хөтөлбөрийн хүрээнд 2021 онд Олон Улсын хөтөлбөрт сургалттай “Шинэ эрин” сургуультай хамтран “Дижитал анги” төслийг санаачлан хэрэгжүүлж элсэлтийн ерөнхий шалгалтын амжилтаар тэргүүлэгч багш нарынхаа удирдлага дор 12 дугаар анги төгсөх 2500 гаруй хүүхдээ цахим давтлагад бэлтгэн ЭЭШ өгснөөс 13 хүүхэд 800 оноо авч дүүргийн хэмжээт онооны дундаж 537,3 оноо болж, өмнөх оноос 21,7 оноогоор ахисан амжилт гаргаад байна.


Сурагчид тэр сургуулийг төгсөхөөр 800 оноо авдаг, нөгөө сургуулийг төгсөхөөр чаддаггүй байх тэр ялгаатай байдлыг өөрчлөхийн төлөө, бас суралцахуйн бэрхшээлтэй хүүхдүүдэд суралцах боломжийг ч энэ хөтөлбөрөөр дамжуулан олгоно гэсэн үг. Эцэг эх, багш, сурагчийн харилцаанаас гадна Баянгол дүүргийн Боловсролын хэлтэс давхар үүрэгтэй оролцох гээд хэд хэдэн үр дүнг “Баянгол-Цахим сургууль” хөтөлбөрөөс хүлээж байна.

Хөтөлбөр дүүргийн хэмжээнд 47 сургуулийн 56000 гаруй сурагчдад хүрнэ. Тиймээс ч ТХБ-II төслийн жижиг төслүүд бидэнд сайн туршилага болж байна.

*“Сургуулиудад цахим студи байгуулахаар төлөвлөсөн байна. Студийг ямар зорилгоор ашиглах вэ?”*

ТХБ-II төслийн түшиц Олон улсын хөтөлбөрт “Шинэ эхлэл” ЕБС цахим студи байгуулаад байна. Энэ туршилагыг нэвтрүүлж нутагшуулаад бүсчилсэн хэлбэрээр дүүргийнхээ 5-6 сургуулийн дунд нэг цахим студи байгуулахаар төлөвлөж “Эрдмийн ундраа” цогцолбор сургуулийг түшиглэн нийт 28 сая төгрөгийн төсөв бүхий “Цахим студи” байгуулж байна. Бидэнд энэ ажлыг дүүргэтээ нэвтрүүлэхийн тулд судалж цаг алдахгүйгээр сайн туршилагыг шууд авч хэрэгжүүлэх, нутагшуулах боломж бий болсонд их талархалтай хандаж байгаа.

Мөн ТХБ-II төслийн түшиц ерөнхий боловсролын лаборатори 28 дугаар сургуулийн сайн туршилагыг ч онцолмоор байна. Тус сургууль төслийн хүрээнд хүүхдүүдээ сонсох аяныг амжилттай хэрэгжүүлж хүүхдийн оролцооны аргаар хүүхэд хамгааллын бодлогод шинэчлэл хийж, жишиг загвар боловсруулж эхэлсэн. Хүүхдүүдэд ямар бэрхшээл тулгарч байна, томчууд алийг нь ойлгохгүй байна, тэдэнд юу хэрэгтэй байна гэдгийг сонсох, шийдвэр гаргахад хүүхдүүд өөрсдөө оролцох энэ загварыг бий болгох арга ажиллагааг нэвтрүүлж байна. Бид 2022 онд 28 дугаар сургуулийнхаа боловсруулсан хүүхэд хамгааллын бодлогод хүүхдийн өөрийн оролцоог дээдлэх энэ загварыг бусад сургуулидаа нэвтрүүлэх боломжийг мөн судалж байна.



*“ТХБ-II төслийн жижиг төслийн нэг гол шалгуур нь багш, сурагч, эцэг эх, орон нутгийн ишидвэр гарах, хэрэгжүүлэх баг хамт олны түншилж хамтын ажиллагаа байдаг. Энэ тал дээр ямар ахиц танай дүүргэт ажиглагдаж байгаа бол?”*

ТХ-II төсөлд хамрагдсан бидний зорилго ч энэ. Бид дүүргийнхээ боловсролын чанар, хүртээмжийг ахисан түвшинд гаргахын тулд сайн туршилагыг судалж, хамтдаа хэрэгжүүлэхийг зорьж байна. Сургуулиудад олон сайн туршилага байдаг ч дангаараа бол өөр өөрсдийнхөө хүрээнд хэрэгжүүлээд дуусдаг. Тэгвэл одоо энэ сайн туршилагыг дүүргийн хэмжээнд авч хэрэгжүүлж, нутагшуулъя. Дөрвөн жилийн дараа эргээд харахад боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарын хөгжил арай өөр түвшинд хүрсэн байна гэж харж байна. Үүний тулд бидэнд яг ингэж түншилж хамтарч ажиллах хэрэгцээ шаардлага тулгарч байна.



Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх Боловсролын хэлтэст эцэг эхчүүдийн дууг хоолойг сонсож, санал солилцох, мэдээ мэдээллийн нэгдсэн баталгаат эх сурвалжаас нэг дор хүлээн авах боломжтой цахим хуудас нээгээд ажиллаж байна. Бид юун дээр алдаж байна, ямар асуудал тулгарч буй сонсохыг хичээж байгаа нь энэ ажлын нэг нь.

*“Баярлалаа.”*

**МЭДЭЭ**

**“ШИНЭ ЭХЛЭЛ” ЦАХИМ СТУДИЭ БАЙГУУЛЛАА**

*“ТХБ-II” төсөлд хамрагдаж, сургуулийнхаа үйл ажиллагаанд “Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага”-ыг нэвтрүүлэхээр ажиллаж байгаа нийслэлийн Баянгол дүүргийн ерөнхий боловсролын сургуулиуд мэдээлж байна.*

\*\*\*

Олон улсын хөтөлбөрийн сургалттай, нийслэлийн ерөнхий боловсролын “Шинэ эхлэл” сургуулийн хамт олон 2020-2021 оны хичээлийн жилд ТХБ-II төслийн жижиг төслөөр “Шинэ эхлэл цахим студи” төслөө боловсруулж, амжилттай хэрэгжүүллээ.

Цахим студийн тоног төхөөрөмжийг бүрэн судалж, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээ худалдан авч, студиэ бүрэн тохижууллаа.



Төсөл хэрэгжих хугацаанд цахим студийг ашиглан, тогтвортой хөгжлийн боловсролын агуулгыг суурь боловсролын түвшинд интеграцчилсан “Хөрс” сэдэвт нэг загвар хөтөлбөр боловсруулж, цахим сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэлээ.

Багш, ажилтан, сурагчдыг тогтвортой хөгжлийн боловсролд өөрийн хувь нэмрээ бодитоор оруулах, зөв хандлага, төлөвшилтэй болох, дахин ашиглагдах материалаар хэрэглээний зүйлс хийх бүтээлч үйл ажиллагаанд сурах, чадавхжуулахад хувь нэмэр оруулах зорилгоор санаачилсан “Хамтдаа хөгжье” нөлөөллийн ажилд багш, ажилтан, сурагч, эцэг эхчүүд бүгд хамрагдлаа. 7-12 дугаар ангийн сурагчид энэ аяны үр дүнгээрээ 11-р сард үзэсгэлэн гаргаж, видео бичлэгээр багш, ажилтан, сурагчид, эцэг эхчүүддээ тайлагналаа.

Манай сургуультай хамтран ажилладаг “Эрдмийн өргөө цогцолбор” сургуулийн хамт олон цахим студийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцсон юм.



“Шинэ эхлэл” ерөнхий боловсролын сургууль.

**СУРГУУЛИУДАД ТУРШЛАГАА ТҮГЭЭЖ, ХАРИЛЦАН СУРАЛЦАЖ ХАМТРАН АЖИЛЛАНА**

Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори “Эрдмийн өргөө” цогцолбор сургууль нь 5765 суралцагч, 250 багш ажиллагсадтай 2020-2022 онд “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийг өөрийн сургууль, орон нутагтаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Манай сургуулийн “Хөгжлийн тулгуур” төсөл “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийн уралдаанд шалгарч, улмаар амжилттай хэрэгжүүлж байна.

Видео хичээлийн арга зүйд суурилан Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг цөм хөтөлбөрийн зорилгуудтай уялдуулан ээлжит хичээлийг бэлтгэж ЕБС-ийн мэргэжил нэгт багш нартаа түгээж, туршилагаа хуваалцаж хамтарч ажиллах нь манай төслийн зорилго юм.

“Хөгжлийн тулгуур” төслийн хүрээнд дараах ажлуудыг хийгээд байна.

- Суралцагч, эцэг эх, багш, ажиллагсад “ТХБ-ийн үзэл баримтлал ба бидний хийж чадах зүйлс” сэдэвт сургалтуудыг үе шаттайгаар зохион байгууллаа.
- ТХЗ-ыг сургуулийн үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөтэй уялдуулан, ээлжит хичээл бүрт тусган суралцагчдад ТХЗ-ыг түгээн дэлгэрүүлсэн.
- ТХ-ийн 17 зорилгыг цөм хөтөлбөрийн зорилтуудтай уялдуулан, ээлжит хичээлүүдийг бэлтгэн видео хичээлийн сантай боллоо.

*“Эрдмийн өргөө” цогцолбор сургууль.*

**СУРАГЧДЫН НЭВТРҮҮЛЭГ ОЛОН НИЙТЭД ЦАЦАГДАХАД БЭЛЭН БОЛЛОО**

Нийслэлийн Баянгол дүүргийн 28 дугаар сургуулийн хамт олон ТХБ-II төслөөр “Хүүхэд хамгааллын түншлэлийг хүүхдийн оролцооны аргаар бэхжүүлэх нь” төсөл хэрэгжүүлж байгаа юм. Энэ төслөөр тус сургуулийн сурагчид хүүхдийн нийтлэг эрхүүдээс 9-ийг сонгож, телевизийн нэвтрүүлэг хийсэн нь олон нийтэд хүрэхэд бэлэн болжээ. Нэвтрүүлгийн зохиолыг багш, сэтгэл зүйч, хүний эрхийн болоод сэтгүүл зүйн мэргэжилтнүүдийн зөвлөгөө туслалцаатайгаар бичиж боловсруулан, өөрсдөө хөтөлж, жүжигчилсэн байдлаар бэлтгэсэн байна. Мөн нэвтрүүлэгт оролцох зочдоо ч өөрсдөө сонгож, ярилцжээ.

- Хүүхдийн хамгаалуулах эрх
- Хүүхдийн чөлөөтэй бодож сэтгэх эрх
- Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх
- Хүүхдийн оролцооны эрх
- Хүүхдийн хөгжих эрх
- Хүүхдийн хүчирхийллээс ангид байх эрх
- Хүүхдийн сурч боловсрох эрх
- Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх
- Хүүхдийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх

“Эдгээр 9 нэвтрүүлгийг Монголын үндэсний олон нийтийн телевиз болон цахим сүлжээгээр дамжуулан түгээж, хүүхдийн оролцоонд тулгуурласан түншлэл-нөлөөллийн загварыг нийгэмд сурталчлахад бэлэн боллоо. Мөн бид техник, технологи, хүний нөөцийн чадавхи дээрээ тулгуурлан “Галт шувуу 28” теле студиэ байгууллаа” гэж 28 дугаар сургуулийн баг танилцууллаа.

Хүүхдийн өмнөөс дан ганц насанд хүрэгчид ярих, асуудлыг тодорхойлох, үндсэн шийдвэрийг гаргах бус хүүхдүүд өөрсдөө санаачилж, гардан хэрэгжүүлэхийг чухалчилснаараа тус төслийг шинэлэг, өвөрмөц шийдэл гэж талууд үзэж байна.

Төслийн үндсэн зорилго нь хүүхдийн оролцоон дээр түшиглэн төр, нутгийн захиргаа, иргэний нийгэм, олон улсын байгууллага, эцэг эхчүүдийн хүүхэд хамгааллын түншлэлийг бэхжүүлэхэд чиглэж, загвар боловсруулахад оршиж байна.

28 дугаар сургуулийн хамт олон өөрсдийн туршилагаа танилцуулах, хуваалцах уулзалт-чуулганыг Баянгол дүүргийнхээ сургуулиудын дунд удахгүй зохион байгуулах юм.


*Ерөнхий боловсролын 28 дугаар сургууль*

Тогтвортой хөгжлийн зорилгуудын цөм нь хүний эрх юм. Тийм учраас хүний эрх баталгаажуулах орчинд тогтвортой хөгжил бүрэлдэн биежих арга зам үгүй гэж үздэг. Хүний эрх нь Тогтвортой хөгжлийн бүх зорилгын хэрэгжилт, түүний ахиц дэвшилээс хамаардагтай адил Тогтвортой хөгжлийн зорилгууд нь хүний эрхийн хүрээнд гарах дэвшилтэй шууд уялдаатай хэрэгждэг болохыг НҮБ онцолсон байдаг.

Энэ жил дэлхийн улс орнууд жил бүрийн 12 сард тохиодог Хүний эрхийн ОУ-ын өдрөөр "ЭРХ ЧӨЛӨӨ-ТЭГШ БОЛОМЖ-ЭВ НЭГДЭЛ" уриан дор дуу хоолойгоо нэгтгэлээ. Энэ өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор болсон Хүний эрхийн үндэсний форум-2021 чуулганаас эдийн засаг, нийгмийн эрхтэй холбогдох сэдвийг "ТХБ" цахим сонин онцолж, зарим илтгэгч, судлаачдын илтгэл, байр суурийг нийтэлж байна.

## ХҮНИЙ ЭРХИЙН ӨНДӨР МЭДРЭМЖТЭЙ ИРГЭНИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ ХАМГААС ЧУХАЛ

**Монгол Улсын Ерөнхийлөгч У.ХҮРЭЛСҮХ:** Хүний эрхийн асуудлаар олон нийтийн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийн ойлголтыг хүүхдэд бага



наснаас нь суулгах, хүний эрхийн өндөр мэдрэмжтэй иргэнийг төлөвшүүлэн бойжуулах нь хамгаас чухал. Ийм учраас ХЭҮК-той нягт хамтран ажиллаж, Ерөнхийлөгчийн ивээл дор жил бүр Хүний эрхийн үндэсний чуулганыг зохион байгуулдаг уламжлалыг сэргээх саналыг сайшаан дэмжлээ.

## НЭГИЙГ НЬ АМЖИЛТТАЙ ШИЙДСНИЙ ДАРАА НӨГӨӨГ НЬ ГЭСЭН ОЙЛГОЛТ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХЭД БАЙДАГГҮЙ



**"Отгон тэнгэр" их сургуулийн багш, судлаач Р.ОЧИРБАЛ:** Жишээ нь иргэний болон улс төрийн эрх дээр цаазын ялыг хуулиар хориглосон л бол хэрэгжилтээ бариад суучихдаг. Харин эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хуулиар хамгаалсан бол уг эрхийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэх бүх механизмыг иж бүрэн тогтолцоот

байдлаар бий болгох ёстой байдаг. Эдгээр эрх бүгд өөр хорондоо хамааралтай. Тухайлбал шилжин суурьшилаас үүдэж УБ-т шийдэх олон асуудал тулгарч байна. Дэд бүтцүүд нь данхайгаад ачааллаа дийлэхгүй болдог. Нэг ангид 30 хүүхэд суух ёстой байхад 50, 60 хүүхэд сурах нөхцөл бий болох гэх зэрэг. Тиймээс эдийн засаг, нийгэм, соёлын эрх нь өөр хоорондоо холбоотой бөгөөд нэгийг амжилттай шийдэж байж нөгөөг нь шийднэ гэсэн ойлголт огт байхгүй.

Энэ эрхийн асуудал явж явж хоёр зүйлээс болж гацаж байна. Нэгдүгээрт хүний эрхийн боловсрол. Иргэд хууль тогтоомж, бодлого, төрийн үйл ажиллагааг төдийлөн мэддэггүйгээс үр өгөөжийг нь сайн хүртэж чаддаггүй. Үүнд боловсролын болоод мэдээлэл олж авах тэгш бус байдал нөлөөлдөг. Тиймээс хүний эрхийн боловсролыг сургуулийн өмнөхөөс эхлээд бүх шатны боловсролын тогтолцоонд цаашлаад насан туршийн боловсролын тогтолцоонд оруулж ирэх ёстой. Үүнд тогтвортой хөгжлийн боловсрол өөрөө маш чухал.

## ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, ХҮНИЙ ЭРХТЭЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГОО УЯЖ, ХӨРӨНГӨӨ ТӨСӨВЛӨХИЙГ АНХААРУУЛЛАА



**Үндэсний аудитын газрын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, тэргүүлэх аудитор Б.БУНДХОРУЛ:**

2020 оны байдлаар хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ өгөхөд дунджаар 78 хувьтай гарсан. Сургуулийн өмнөх боловсролд 5, тусгай хэрэгцээт боловсролд 1, ерөнхий боловсролд 7, насан туршийн боловсролд 1, их дээд боловсролд 4, шинжлэх ухаан, технологийн салбарт 3 гээд нийт 1.5 их наяд төгрөгийн 21 хөтөлбөр хэрэгжсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд 31 сургууль, 63 цэцэрлэг, 22 дотуур байр, 12 спортын

танхимыг тус тус ашиглалтад оруулж, сургуулийн суудал 35 500, цэцэрлэг 10 000, дотуур байр 1 300 орчим хүүхдийн хүчин чадлаар нэмэгджээ.

Манай улсад бодлогын бичиг баримт, хууль дүрэм хангалттай байгаа ч хоорондын уялдаа холбоо хангалтгүй, хууль дүрмийг дагаж гарах журам дүрэм хугацаа алдах нь их байна. Тогтвортой хөгжил, хүний суурь эрх, эрх чөлөөтэй хөгжлийн бодлогоо уяж, төсөв хөрөнгөө зарцуулж байхыг мөн анхааруулсан. Тухайлбал хамран сургах тойрогт нь сургууль, цэцэрлэг хүрэлцдэггүй, томоохон цогцолбор хороолол нь сургууль, цэцэрлэггүй төлөвлөгддөг байдал үргэлжилсээр байна.



## БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ЯЛГААТАЙ БАЙДАЛ ДААМЖИРВАЛ НӨХӨЖ ГҮЙЦЭХЭД ХҮНД



**Хүний эрхийн форумын гишүүн "Нээлттэй нийгэм форум" ТББ-ын хуулийн хөтөлбөрийн менежер Б.ХИШИГСАЙХАН:**

Тогтвортой хөгжлийн гол шалгуур үзүүлэлт нь хүний эрх юм. Саяхан хийсэн эдийн засгийн чиглэлийн нэг судалгаагаар дээд боловсролтой хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт нь дунд, бага боловсролтой иргэдийнхээс хамаагүй өндөр болохыг харуулсан байсан. Гэвч энэ цар тахлын үед хүмүүсийн сурч боловсрох эрх нь хумигдаж байна. Энэ бол тэгш бус байдлыг гүнзгийрүүлэхээс эхлээд олон сөрөг үр дагавартай. Мөн цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж алслагдсан газар нутгийн хүүхдүүдийн боловсрол эзэмших боломж хумигдаж хоцорч байна. Төрийн өмчит сургуулиуд хичээл нэг бүрийг цахимаар орж чадаагүй. Ялангуяа 2020 оны цахим сургалтад сайн ахиц гараагүй, дээр нь хичээлийн агуулгыг сайн ойлгож чадаагүй гэсэн гомдол санал ч гарсан. Ийм ялгаатай байдал боловсролын салбарт газар авбал нөхөж гүйцэхэд хүнд болно.



## БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ МАШ ЧУХАЛ

**"Бүх нийт боловсролын төлөө" иргэний нийгмийн үндэсний эвслийн зохицуулагч Б.ТУНГАЛАГ:**

Тогтвортой хөгжлийн бүх зорилгын цаана хүний нэг ба түүнээс дээш эрх бий. Олонх улс оронд энэ цаг үед сурч боловсрох эрхийн нөхцөл байдалд ухралт гарч байгааг дэлхий даяараа хүлээн зөвшөөр байна.

Бид өнөөдөр боловсролыг хардаг өнцгөө өөрчилмөөр байна. Үүний нэг арга зам нь тогтвортой хөгжлийн боловсрол олгох явдал гэж харж байна. Өнөөдөр сургалтын хөтөлбөрийг шинэчлэх үү, сургуулийн соёл, засаглал удирдлагыг шинэчлэх үү, багш бэлтгэх арга өөрчлөх үү гэж ярьж, арга зам хайж байна. Үүнийг "шинэ хэвийн" гэж тодорхойлж яриад байгаа. Өмнө нь хэвийн гэж ярьж бодож байснаа өөрчилж шинэчлээд хэвийн болгоно гэсэн үг. Өнөөдөр бидэнд хэвийн болсон, дадсан хөтөлбөрийн зорилго өөрчлөгдөхөөс өөр арга байхгүй. Бид өнөөдөр дэлхийн иргэн бэлтгэх шаардлага тулгараад байна.



## "ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ" ГЭЖ НЭРЛҮҮЛЭХЭЭС АЙЖ БАЙНА



**Монголын тэргэнцэртэй иргэдийн холбооны тэргүүн Б.ЧУЛУУНДОЛГОР:**

Бид "Тусгай хэрэгцээт" гэж нэрлүүлэхээс айж байна. Ингэж нэрлэснээр биднийг нийгмээс, орчноос тусгаарлах хандлагыг өөгшүүлж ч болох юм. Хөгжлийн бэрхшээлтэй гэж нэрлэх нь илүү дээр гэж үздэг. Биднийг бусадтай л адилхан оролцож, хэлэлцэж, хийж байхад гайхаж, хэт дөвийлгөж, магтан дуулж харьцах нь их эвгүй. Энэ нь чадамжгүй, өрөвдөлтэй хүмүүс гэх уламжлалт, буруу хандлага л даа. Орчны саадыг шийдээд, "иш эвий", "хөөрхий" гэх хандлага л өөрчилчихвөл бидэнд өөр бэрхшээл байхгүй. Япон, Солонгос зэрэг бусад улсад оюун санаагаа удирдах боломжгүйг л хөгжлийн бэрхшээл гэж үздэг. Бусад үед бидний хэнд нь ч яг ижилхэн сурч боловсорч, оролцож, ажиллаж, амьдрах чадвар бий.

Өнөөдөр Монгол улсад 106 400 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэн бий. Тэдний олонх нь буюу 90 000 нь хөдөлмөрийн насных. Гэвч тэдний 20 хүрэхгүй хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байна.



## БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЗАРДЛЫГ УЛСЫН ТӨСВИЙН 20 ХУВЬД ХҮРГЭХ ШААРДЛАГАТАЙ



**Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэгийн гүйцэтгэх захирал Б.БАТЖАРГАЛ:**

Тогтвортой хөгжлийн зорилт нь тэгш хамруулсан, эрх тэгш байдлыг баталгаажуулсан чанартай боловсрол болон насан туршдаа суралцахуйг хүн бүрт гэсэн ерөнхий санаатай. Үүнийг хэрэгжүүлэхэд нөөц хэрэгтэй. Энэ нөөцийг хангахад санхүүжилт хамгийн чухал. Асар удам нутагтай, хүн ам тархай суурьшсан, удаан хугацаанд хүйтэрдэгтэй холбоотой манай улсын боловсролын салбарын зардал их өсдөг. Тийм ч учраас манай төсөвт эзлэх боловсролын зардал ОУ-ын жишгийн дээд хязгаар 20 хувьд ойртох шаардлагатай. ОУ-ын жишгээр бол төсвийнхөө 15-20 хувийг, эсвэл ДНБ-нийхээ 4-6 хувийг боловсролоор зарцуулдаг.

БШУЯ-ны мэдээгээр 2022 онд нийт төсвийн 13 хувийг энэ салбарт зарцуулах юм байна. Дээр дурьдсан онцлогыг тооцвол энэ нь бага хөрөнгө. Тухайлбал боловсролын тусгай, ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдтэй ажиллах мэргэжлийн чадварлаг багш байх ёстой. Тэр багшийг бэлтгэх, тасралтгүй хөгжүүлэх, багшид шаардлагатай бусад дэмжлэгүүдийг өгөх санхүүжилт байна уу манайд? Дохионы хэлний, сэтгэл зүйч, мэргэжлийн чиг баримжаа олгох, хүүхэд хөгжлийн үйл ажиллагаа эрхлэх нарийн мэргэжилтнүүдийн, сурах бичгийн дэмжлэг хэр байна?

Өнөөдрийн дотуур байрны хүүхдийн хувьсах зардал бол зөвхөн тэнд хонох, хооллох л зардал. Гэтэл жилийн 9 сар, хоногийн 24 цаг амьдарч байгаа хүүхдийн хамгаалал, хөгжил, оролцоог яах вэ? Мөн төсөвлөөд байгаа мөнгө нь хүүхдүүдээ, суралцагчиддаа, сургуульд яаж хүрч байна гэдэг нь ч чухал. Эдгээр асуудлыг шийдэхийн тулд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаа шинэчилж, илүү нарийвчлах шаардлагатай болж байна. Нөгөө талд төсвийн зарцуулалтын хяналтыг төрөөс гадна эцэг эх, иргэний нийгмийн төлөөлөл бүх түвшинд хийдэг байх ёстой. Эдгээр саналаа бид Хүний эрхийн үндэсний форумын зөвлөмжид тусгуулахаар гаргаж тавилаа.



*ТХБ-ОРОН НУТАГ булангаа  
ТХБ-II төслийн түшиц аймгуудын  
нэг Архангай-аас бэлтгэлээ.*

## ТУРШИЛТИЙН ТАЛБАЙ, ХАЛУУН УС, НУТГИЙН БРЭНДТЭЙ АРХАНГАЙН СУРГУУЛИУД

*/Сурагч, багш, эцэг эхчүүдийн тогтвортой  
хөгжлийн боловсролын төлөөх алхамууд/*

"Тогтвортой хөгжлийн боловсрол-II" /ТХБ-II/ төслийн Техникийн зөвлөн зохицуулах үндэсний баг /ТЗЗҮБ/ өнгөрсөн 10 дугаар сард Архангай, Булган, Хэнтий, Хөвсгөл, Ховд аймаг, Улаанбаатар хотын Сонгино хайрхан, Баянгол дүүрэг дэх сургуулиудад хэрэгжүүлж буй Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн үйл явцтай газар дээр нь танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Дээрх аймаг, хотын 30 сургууль нь ТХБ-II төслийн түшиц сургуулиуд бөгөөд сургууль тус бүр нийт 15 сая төгрөгийн өртөгтэй жижиг төсөл хэрэгжүүлж байгаа юм. Төсвийг ТХБ-II төсөл, орон нутгийн төсвөөс хамтран санхүүжиж байгаа юм. Сурагч, эцэг эх, багш сургуулийн удирдлага багаар, бүхлээр ажиллах арга хандлагад суралцах, тогтвортой хөгжлийн төлөө зорилго, үйл ажиллагаагаа тодорхойлж, үйлдэл хийх сэдэл тэмүүллийг өрнүүлдэг, энэ нь сургуулийнхаа орчин, орон нутагтаа нөлөөлж, олон нийтийг тогтвортой хөгжлийн төлөө уриалж, сэдэлжүүлдгээрээ тус төслийн үнэ цэнэ оршдог юм.

БШУЯ, БОАЖЯ, Швейцарын хөгжлийн агентлагын хамтран хэрэгжүүлж буй ТХБ-II төслийн үндэсний түшиц байгууллагаар Боловсролын хүрээлэн, орон нутгийн түшиц байгууллагаар Байгаль орчин, мэдээлэл сургалтын төв ажиллаж байна.

## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИГЧ УЛСЫН ЗАГВАР СУРГУУЛЬ БОЛНО

*/Архангай аймагт ТХБ-II төслийн  
түшиц дөрвөн сургууль бий/*

Сургуулийнхаа доторх задгай талбай, коридорт модлог голдуу ургамал цэцгийг англи, монгол нэр, тайлбартай байрлуулжээ. Давхар бүртээ хогоо ангилан ялгах савнуудтай. Гадаад талбайн гэрлүүд нь нарны эрчим хүчээр цэнэглэгддэг. Энэ бол Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн хамт олны тогтвортой хөгжлийн төлөөх санаачлагуудын зарим нь.

Тус сургууль ТХБ-II төслийн хүрээнд хог хаягдлаа эх үүсвэр дээр нь бууруулах, ангилан ялгах, сургуульдаа эко орчин бүрдүүлэх зорилгоор "Ногоон ирээдүй" төсөл санаачлан энэ оноос хэрэгжүүлж эхэлжээ. Мөн гаднаа сэтгэхүй хөгжүүлэх тоглоомын талбайг байгуулахаар нутгийн үйлвэрлэгч, шагайн өв тээгч Х.Багбаяртай хамтран ажиллаж байна.

1700-аад сурагч, 120 гаруй багш, ажиллагсадтай энэ хамт олон тогтвортой хөгжлийн боловсролыг /ТХБ/ дэмжигч улсын загвар сургууль болох зорилт дэвшүүлсэн танилцуулж байсан юм.

*Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 2 дугаар  
сургуулийн захирал Н.ГЭРЭЛЧУЛУУН:*



Сургуулийн гадаад, дотоод орчинг ногооруулах гээд зөвхөн сургуулийнхаа тохижилт, орчинг өөрчлөөд байгаа мэт боловч сурагч, багш, эцэг эхчүүдийн ТХБ-д чиглэсэн, тогтвортой хөгжлийн үзэл санааг төлөвшүүлэх ажлууд давхар явж байдаг. Тухайлбал нараар цэнэглэгддэг гэрэлтүүлэг, мэдрэгчтэй угаалтуур, хог хаягдлаа ангилах сав зэрэг нь цаанаа байгаль дэлхийдээ ээлтэй, хэмнэлттэй амьдрах, зөв дадал хэвшилд суралцахын ач тусыг таниулж, хэвшүүлэх зорилготой.

Нөгөө талд бид хичээл сургалтын агуулга тус бүрт нь тогтвортой хөгжлийн үзэл санааг суулгаж, ТХБ-ыг судлагдахуун бүрт шингээж өгч байна. Энэ хичээлийн жилд манай сургууль ганцаарчилсан сургалтын буюу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч хөгжих танхим, сэтгэл зүйчийн танхим гээд хоёр шинэ танхим нээлээ.

Танхимууд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр бүрэн хангагдаж байна. Энэ бол мөн л хэнийг ч орхихгүй, хамтдаа хөгжих тогтвортой хөгжлийн үндсэн зарчим хангагдах бас нэг том алхам юм.



## ЗАРИМ ХИЧЭЭЛ ТУРШИЛТЫН ТАЛБАЙД ОРНО

Архангай аймгийн ерөнхий боловсролын 3 дугаар сургууль ТХБ-II төслийн хүрээнд дөрвөн улирлын хүлэмж, түүнийг түшиглэсэн хичээл-сургалтын төв байгуулахаар ажлаа эхэлжээ. Тус сургалтын төв нь хүүхэд багачуудад байгаль орчноо хамгаалах, танин мэдэх сэтгэлгээг хөгжүүлж бэхжүүлэх, улмаар тогтвортой хөгжлийн үзэл санааг ойлгох, бататгах, шинжлэн судлах ач холбогдолтой гэж санаачлагчид нь үзэж байна. Сургалтын талбайд орох хичээлийн нэгдсэн хөтөлбөрөө боловсруулснаа ч сургуулийн багш мөн танилцуулаа.

3-р сургууль шинэ хичээлийн жилд 1580 гаруй сурагчдаа нээлттэй буюу коридорын номын сантай угтсан юм. Сурагчид хичээлийн завсарлага, чөлөөт цагаараа сургуулийнхаа задгай талбайд тухлангаа номоо уншиж, хичээлээ давтах бололцоотой болжээ. "Дэлхийн зөн" ОУ-ын байгууллага 1.2 сая төгрөгийн ном хандивласан бол шаардагдах материалыг эцэг эхчүүдийн хандив тусламжаар авч, багш ажиллагсад нь тавиур, ширээгээ урлажээ.

"Энэ бол ТХБ-ын сургууль бүхлээр ажиллах арга хандлагад суралцаж буйн үр дүнд бүтээсэн ажил" гэж сургуулийн багш нар хэлж байлаа.

10 дугаар сард цар тахлаас шалтгаалан хүүхдүүд нь цахимаар хичээллэж байсан болохоор коридорын номын сангаа нээж амжаагүй байлаа.



*Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 3 дугаар сургуулийн  
захирал Б.ЭНХБОЛД:*

ТХБ-II төслийн хүрээнд байгуулж байгаа хичээл-туршилтын талбай нь салхины зүг чиг хурдыг хэмжих хэсэг, хөрс мандлын талбай, дөрвөн 4 улирлын хүлэмж, мэдээллийн цэг зэргээс бүрдэнэ. 4-11 ангийн сурагчдад танхимын бус сургалтыг энэ талбайдаа зохион байгуулахаар төлөвлөсөн. Тухайн сургалтын агуулга, хөтөлбөрөө ч энэ чиглэлээр боловсруулаад байна.

## СУРАГЧИД СУМЫНХАА ХАЛУУН УСАНД ДУГААРЛАХГҮЙ

Архангай аймгийн Батцэнгэл сумын сургууль Швейцаруудын тогтвортой хөгжлийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх үйлсэд хандивласан, мөн орон нутгийн төсвөөс олгосон нийт 15 сая төгрөгөөр дотуур байрандаа халуун ус барьж, жорлон, угаалтуураа шинэчиллээ.

Ингэснээр сургуулийн дотуур байрны сурагчид нэг зэрэг дөрвөн хүнд үйлчлэх тохь тухтай халуун ус, бас боловсон ариун цэврийн өрөө, угаалтууртай болоод байна. Ингэж сургуулийн хамт олны ТХБ-II төслийн хүрээнд санаачлан хэрэгжүүлсэн "Зохистой хэрэглээ-Зөв дадал" төсөл нь дотуур байрны сурагчдын амьдрах, сурах орчинг сайжруулжээ. Зарим газар ийм бүтээн байгуулалт 90 хүртэл сая төгрөгийн төсөв өртөгтэй байдаг тухай сургуулийн багш нар хэлж байлаа.



*Архангай аймгийн Батцэнгэл сумын сургуулийн монгол  
хэлний багш Г.НЯМ-АДЪЯА:* Энэ бол бидний амьдралаас урган гарсан эрэлт хэрэгцээ. Эхлээд сургууль бүхлээр ажиллах арга хандлагын хүрээнд өөртөө үнэлгээ хийсэн. 65 багш, 130 сурагч, 28 төрийн албан хаагч, 140 гаруй эцэг эх судалгаанд хамрагдсанаас

олонхи нь дотуур байр нь халуун усгүй, усанд орох боломжгүйг тодорхойлж, эрүүл ахуйн шаардлага хангахгүй байгааг өөрчлөх санал өгсөн.

Ингээд дотуур байрны гурван өрөөг багш ажиллагсад өөрсдөө тохижуулж халуун усны өрөөтэй боллоо. Мөн жорлонгийн хоёр суултуур, зургаан гар угаалтуурыг сольж шинэчилсэн.



## "ЭЭЖ ОХИД" КЛУБ НУТГИЙН БРЭНД ҮЙЛДВЭРЛЭНЭ

Архангай аймгийн Тариат сумын ерөнхий боловсролын сургуулийн багш, ажиллагсад, эцэг эхчүүд ТХБ-II төслийн хүрээнд "Нутгийн брэнд-Үнэт баялаг" төсөл санаачилжээ. Сургуулиа түшиглэн байгуулсан "Ээж охид" клубын гишүүд нь сарлагийн хөөврөөр бүтээгдэхүүн нэхэж нутгийн брэнд үйлдвэрлэхээр нэхмэлийн машинаа захиалан авчээ.

*Архангай Тариат сумын ерөнхий боловсролын сургуулийн  
захирал М.БОЛОР-ЭРДЭНЭ:*



Манай Тариат сумын бор сарлагийн хөөвөр нь ноолуурын энд хүрэх чанартай, ээлтэй. Энэ төсөлд технологийн багш нар, сурагч, ээжүүд, сургуулийн ажилтнууд хамрагдаж, хамтаараа суралцаж, ажиллах боломжтой. Бидний төсөл амжилттай хэрэгжсэнээр нутгийн иргэдэд сэдэл тэмүүлэл ч бий болно.

## АСУУДЛАА ХАМТААРАА ТОДОРХОЙЛЖ ТООЦООТОЙ ХАНДСАН НЬ АМЖИЛТАД ХҮРЧ БАЙНА

*ТХБ-II төслийн орон нутгийн  
түшиц байгууллага Байгаль  
орчин, мэдээлэл сургалтын төв  
ТББ-ын сургалтын албаны дарга  
Ш.ОЮУНЦЭЦЭГ:*

Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан бид сургуулиудад зөвлөн туслах, чиглүүлэх ажлаа цахимаар өгч байсан. Төсөлд хийсвэрээр, сэтгэл хөдлөлөөр хандсан зарим сургуульд бэрхшээл учирч байгаа бол хамтаараа асуудлаа тодорхойлсон, судалгаа тооцоотой хандсан сургуулиуд тун ахицтай ажиллаж байна.



*ТХБ-II төслийн ТЗЗҮБ-ийн гишүүн, МУБИС-ийн гадаад  
харилцааны албаны дарга Д.ҮҮРИЙНТҮЯА:*



Тогтвортой хөгжилд хүрэх хамгийн гол хөтөч нь багш, сургуулийн орчин. Тэр ч утгаараа ТХБ-ын үзэл санаа, үнэт зүйлийг төлөвшүүлэхэд сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага нэн чухал. Байгууллага бүтцээрээ, сургууль бүхлээрээ ажиллаж байж, аймаг орон нутаг нийтийн үйл хэрэг болгож байж сая тогтвортой хөгжлийн төлөөх хандлага, үнэт зүйл төлөвшдөг гэж үздэг.

Яг ингэж бүхлээр ажиллах түншлэлийн арга барилыг сайн нэвтрүүлсэн сургуулиуд амжилттай ажиллаж байна. Цар тахал, цахим үйл ажиллагаа төслийн үр дүнд тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа нь ажиглагдлаа. Мөн бараа, үйлчилгээний үнэ өсөх зэрэг бэрхшээлүүд ч байна. Гэсэн ч Архангай аймгийн Батцэнгэл сумын сургууль, Эрдэнэбулган сумын 2, 3 дугаар сургууль төслүүдээ амжилттай хэрэгжүүлж байна. Бид тулгарсан бэрхшээл, шийдвэрлэх асуудлуудын талаар цааш нь уламжилна. Тодорхой шийдэлд хүрнэ итгэж байна. Архангай аймгийн удирдлагын баг ч төслийн үйл ажиллагааг дэмжин санхүүжилтээ шуурхай шийднэ гэдэгт итгэж байна.

*СЭТГҮҮЛЧ Д.ДАВААДУЛАМ*



**БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЭДЭЭЛЭЛ  
СУРГАЛТЫН ТӨВ  
НҮТББ**

Улаанбаатар хот 14210  
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо  
Элчингийн гудамж

**И-майл:** info@feemongolia.mn  
**Вэбсайт:** feemongolia.mn  
**Утас:** +976 88111893



**БОЛОВСРОЛЫН  
ХҮРЭЭЛЭН**

Улаанбаатар хот 14191  
Сүхбаатар дүүрэг 8-р хороо  
Энхтайваны өргөн чөлөө-10  
Багшийн хөгжлийн ордны 4 давхар

**И-майл:** info@esd.mn info@mier.mn  
**Утас:** +976 70125286 +976 80474838  
**Вэбсайт:** www.mier.mn

